

**Улаанбаатар: ӨНӨӨДӨР**

Өдөр -16  
Шөнө -24

**УЛС ТӨР**

ШӨНИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ  
ТӨЛБӨРӨӨС ЧӨЛӨӨЛНӨ

II нүүрт

**ОНИЦЛОХ ХУУДАС**

ГОВЬСҮМБЭРЧҮҮД ИРЭЭДҮЙДЭЭ ИТГЭЛТЭЙ  
БАЙГААГАА ИЛЭРХИЙЛЛЭЭ

V-VI нүүрт

Дугаарын **60** мөр

ҮЗЭЛ БОДОЛ

Аль хэдийнэ л цахилгааны шөнийн тарифыг тэглэх байсан юм

**Н.ПУНЦАГБОЛД**

Улаанбаатар хотын агаарын бохирдол дээд цэгтээ хүрээд, гамшгийн хэмжээнд тулчихаад хэчнээн ч жилийг үдэв бүү мэд. Сүүлдээ иргэд агаарын бохирдлыг тэсч давахаа больж, нийслэлийн бүх л бага насны хүүхэд эмнэлгийг дүүргэчихээд байна. Хатуухан хэлэхэд, цэцэрлэгтээ явж байгаа бага насны хүүхэд бараг л алга байна шүү дээ. Өнгөрсөн хугацаанд төр засгаас утаатай тэмцээгүй биш тэмцсэн. Гэхдээ яг утаатай тэмцсэн үү, харин тэмцэж байгаа нэрийдлээр хэдэн компанийн бизнесийг дэмжсэн үү гэдэг нь ярих л асуудал.

Үргэлжлэл нь III нүүрт

**Н.ПУНЦАГБОЛД**

Хамгийн түрүүнд бодогдож байгаа зүйл бол өр. 2017 онд бид 1.6 их наяд төгрөгийн зээл төлөх ёстой. Энэ талаар Сангийн сайд Б.Чойжилсүрэн ажлаа хүлээж авсныхаа дараа МҮОНТ-ээр сүр бадруулан мэдээлсэн. Тийм болохоор 2017 онд энэ их өрийг яаж төлөх вэ гэдэг асуудал л монголчуудын, Монгол Улсын Засгийн газрын гол санаа зовох асуудал болох байх. Түүнээс өөр нэг их сүр бадруулаад

байхаар юм болохгүй. Гэхдээ Ерөнхийлөгчийн сонгуулийг мартаж болохгүй биз ээ. Магадгүй гадаад ор төлөхөөс илүү ач холбогдолтой нь Ерөнхийлөгчийн сонгууль ч байж болох. Ерөөсөө манай улс сонгуулиас сонгуулийн хооронд л бодлого боловсруулж, ард түмнээ аргалж явсаар

өдийг хүрсэн. Ирэх жил ч энэ бүхэн өөрчлөгдчихгүй байх. Тэртэй тэргүй Ерөнхийлөгчийн сонгуулийн "дайн" аль эртнээс эхлээд, тартагтаа тулчихсан. АН-аас Ерөнхийлөгчийн сонгуультай холбогдсон бүхий л хүмүүсийг шалгаж, нэгжиж, эргэн тойр-

ны хүмүүсийг нь баривчилж хорьдог "гоё" тогтолцоо бий болоод удаж байна. Харин МАН-аас бол ердөө ганц, хоёрхон хүний л нэр яригдаж байгаа юм. Тэр дундаа МАН-ын дарга хамгийн өндөр магадлалтай болов уу. Мань хүний гол зорьж байгаа албан тушаал нь Ерөнхийлөгч. Тиймдээ ч сонгуульд ялалт байгуулсан намын дарга Ерөнхий сайд байна гэсэн дүрмийг дагалгүй УИХ-ын

даргын суудалд суусан гээд байгаа. Энэ үнэний ортой байх. Харин АН-аастүүнтэй хэн өрсөлдөх нь вэ гэдэг сонин байна. Бас

МАХН-аас нэг хүн өрсөлдөх эрхтэй. Намын дарга Н.Энхбаяр бол өрсөлдөх эрхгүй. АН, МАН-ын нэр дэвшигчидтэй ойролцоо үзчих чадалтай улстөрч энэ намаас гарахгүй. Гол өрсөлдөөн хоёр том намын хооронд болно. Ард түмэн МАН-ыг сонгосон сонголтгоо баталгаажуулж, итгэл үзүүлэх нь үү. Эсвэл энэ намын одоо хийж байгаа ажилд үнэлэлт дүгнэлт өгч, АН-ын нэр дэвшигчийг сонгох уу гэдэг нь сонин. Хамгийн гол асуудал ирэх 2017 онд Монгол Улсын элгээрээ хэвтсэн эдийн засаг жаахан өндийх үү, ард түмний амьдрал сайжрах уу гэдгээс бүх зүйл шалтгаалах нь тодорхой.

Үргэлжлэл нь III нүүрт

**ЧУУЛГАНЫ ТАНХИМААС**

## Б.БАТБАЯР: ХӨГЖЛИЙН БАНКНЫ ОЛГОСОН НИЙТ ЗЭЭЛИЙН 92.2 ХУВЬ НЬ ТӨЛӨГДӨӨГҮЙ БАЙНА

**Ж.ОТГОН**

УИХ-ын чуулганаар Хөгжлийн банкны талаар авах зарим арга хэмжээний тухай асуудлыг хэлэлцлээ. Уг асуудлаар АН тав хоногийн завсарлага аваад байсан. Харин хуралдаан даргалагч УИХ-ын дэд дарга Ц.Нямдорж, УИХ дахь АН-ын бүлгийг үүсээд буй нөхцөл байдлыг тооцож үзээд завсарлагын хугацааг наашилуулахыг хүссэн учир тэд асуудлыг судлаж үзээд уг асуудлыг хэлэлцэхээр болсон. Ингээд чуулганаар Хөгжлийн банкны талаар авах зарим арга хэмжээний тухай асуудлыг хэлэлцэхэд хаалттай, нээлттэй хэлэлцэнэ хэмээн гишүүд санал зөрөлдсөн тул санал хурааж, нээлттэй хэлэлцүүлэхээр болсон юм.

Үргэлжлэл нь II нүүрт

## МЭНДЧИЛТЭЭ




Хоёр мянганы түүхийг бүтээж, төрт ёс, есөн зууны эзэнт гүрнийг төвшитгөн төвхнүүлсэн Эзэн Чингис хааныхаа алтан ургийн хаадын гал голомтыг өвлөн, тост Боржигины бор толгодынхоо дунд ажил хөдөлмөр, амжилт бүтээл, баяр цэнгэлээр дүүрэн байгаа Говьсүмбэрчүүд та бүхэндээ айлчлан ирж буй шинэ оны мэндийг дэвшүүлье.

2016 оны аймаг, нийслэлийн ИТХ-ын ээлжит сонгуулийн үр дүнгээр байгуулагдсан аймгийн ИТХ, орон нутгийн удирдлага ард иргэдийнхээ оролцоотойгоор ирэх дөрвөн жилд хийж хэрэгжүүлэх ажил, баримтлах бодлого зорилтоо тодорхойлж, хэрэгжүүлж эхлээд байна.

Ирж буй шинэ онд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаанд тулгуурласан хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, эдийн засгийн тогтвортой хөгжил, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар өрхийн амьжиргааг дээшлүүлэн, ард иргэдээ аюулгүй, эрүүл, тав тухтай орчинд амьдарч, сурч боловсрох таатай нөхцлийг бүрдүүлэн, аймаг орон нутгаа хөгжүүлэхийн төлөө бид чармайн ажиллах болно.

Аймгийнхаа нийт иргэддээ морилон ирж буй шинэ ондоо хүн бүрийн аз хийморь нь өөдөө байж, айл хотлоороо эрүүл энх, элбэг дэлбэг, төвшин жаргалаар бялхаж байхын өлзийтэй ерөөлийг өөд өөд нь өргөн дэвшүүлье.

ИТХ-ЫН ДАРГА



Г.БАТЗАМ

ЗАСАГ ДАРГА



Г.БАТСУҮРЬ

## МОНГОЛЫН МЭДЭЭ

**Манай сонины I улирлын захиалга явагдаж байна**

**Захиалгын үнэ 22400**

Монгол шуудан: 70078977  
УБ шуудан: 70127027  
Скай пост: 70121294  
Түгээмэл шуудан: 70115025

ХААН банк	Авах		Зарах		Хуудалгаа хөгжлийн банк	Авах		Зарах	
	АМ.ДОЛЛАР	ЕВРО	ИЕН	ФУНТ		АМ.ДОЛЛАР	ЕВРО	ИЕН	ФУНТ
	2482.00	2567.00	20.98	3000.00	2482.00	2547.00	20.77	2992.00	
	2496.00	2637.00	21.46	3104.00	2496.00	2667.00	21.75	3128.00	
				39.10				38.78	
				357.00				43.84	
								356.50	
								360.40	

Өчигдрийн 19.00 цагийн байдлаар

## УЛС ТӨР

## ЧУУЛГАНЫ ТАНХИМААС



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

## Шөнийн эрчим хүчний төлбөрөөс чөлөөлнө

Улаанбаатар хотын хэмжээнд агаарын бохирдол тулгамдсан асуудал болсон. Энэ талаар Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат мэдээлэл хийлээ. Тэрбээр мэдээллийн эхэнд “Агаарын бохирдлыг зөвхөн түлш, зуухтай ноцолдсоноор бууруулж, үр дүн гаргах боломжгүй байгаа. Тийм учраас эрдэмтдийг энэ чиглэлд ажиллаач ээ гэсэн хүсэлт тавьсан. Эрдэмтэд маань хүлээж авсан. Засгийн газраас хэд хэдэн арга хэмжээ авах ёстой гэж харж байгаа. Эхнийх нь орон сууцжуулах асуудал. Гэвч хотын бүх гэр хорооллыг орон сууцжуулна гэдэг хүнд. БНХАУ-ын Ерөнхий сайд манай улсад айлчлах үеэрээ 50 сая ам.доллар өгөхөөр амласан, түүгээр орон сууц барих асуудлыг эхний ээлжинд шийдье гэж Засгийн газар үзсэн. Хоёрдугаарт, Агаарын бохирдлыг бууруулах үндэсний зөвлөл хуралдаж гэр хорооллын айл өрхүүдийн шөнийн цахилгааны тарифыг тэглэхээр болсон. Гэхдээ цахилгаанаар дулааны эрчим хүч үйлдвэрлэхэд одоогийн байгаа технологи, тоног төхөөрөмж маань хэрэглээгээ хангаж дийлэхгүй учраас хямд өртөгтэй цахилгаанаар дулаан бий болгодог технологийг бий болгож, санаачлаач гэдэг саналыг эрдэмтдэд тавьсан” гэлээ. Ерөнхий сайдын тэмдэглэснээр агаарын бохирдолтой тэмцэхийн тулд өнгөрсөн хугацаанд 130-140 тэрбум төгрөг зарцуулжээ. Гэвч үр дүн бага байгаа тул Засгийн газар утаагүй зуух, утаагүй түлш үйлдвэрлэж хэрэглээнд нэвтрүүлэх бодлого барихгүй хэмээн шийджээ.

...Хөгжлийн банкнийг эргээд харахад үр могой төрүүлсэн байна. Бүтэн нэг жилийн төсвийн орлоготой тэнцэх хэмжээний мөнгө үрэн таран хийсэн байна. Үүнийг нь ярих гэхээр зээлжих зэрэглэл буурна, адилхан хувааж идсэн уусан гэдэг зүйл ярьдаг...

## Төгсгөл. Түрүүч нь I нүүрт

УИХ-ын гишүүдийн хувьд Хөгжлийн банк улсын төсвөөс санхүүжүүлсэн төслүүдийн 3.2 их наяд төгрөгийн өр авлагын асуудлыг хэрхэн шийдэх, Хөгжлийн банкны шинэ удирдлага цаашид хүндрэлтэй байдлаас хэрхэн гарах, ямар арга хэмжээ авах, төсөл хэрэгжүүлээгүй атлаа мөнгөө авсан компаниудын асуудалд эзэн байгаа эсэх, хариуцаагаар тооцоо уу гэдгийг илүүтэй тодруулж байлаа.

Сангийн сайд Б.Чойжилсүрэн “Хөгжлийн банкны удирдлагад өр авлагын алдагдлыг бууруулах чиглэл өгсөн. Гэтэл тэд эргэн

төлөгдөх нөхцөлтэйгөөр улсын төсвөөс санхүүжүүлсэн төслүүдийн өр авлагыг барагдуулахад хүнд байгааг хэлсэн. Хөгжлийн банкнаас олгосон 5.9 их наяд төгрөгийн зээлийн багцын 54.5 хувь буюу 3.2 их наяд төгрөгийг улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлд олгосон бөгөөд үүнтэй холбогдон Засгийн газар, Хөгжлийн банк хооронд хүү, үндсэн төлбөр, ханшийн зөрүүний өр авлагын тооцоо үүссэн. Иймд Засгийн газрын зүгээс улсын төсвөөс санхүүжүүлсэн болон Хөгжлийн банкны санхүүжүүлж чадах төслүүдэд хувааж авах шаардлага гарсан. Ингэснээр Хөгжлийн банкны бие даан ажиллах чадварыг хангаж өгнө. Энэ ч утгаараа тогтоолд хугацаа зааж өр, авлагын алдагдлыг хаахаар болсон. Хаана хэдэг нь өр авлага авахгүй гэсэн үг биш. Хариуцлагын асуудлыг ч орхиулахгүй. Нөгөөтэйгүүр, улсын төсөв, Засгийн газар баталгаа гаргаад зээлийн асуудлыг шийдсэн нь Хөгжлийн банкны өөрийн хөрөнгийн байдлыг хүндрүүлсэн. Тиймээс хүнд байдлаас гаргахын тулд Хөгжлийн банкинд дэмжлэг үзүүлэх шаардлагатай байна” хэмээн хариулав.

Харин Хөгжлийн банкны гүйцэтгэх захирал Б.Батбаяр “Банк байгуулагдсанаас хойших хугацаанд олгосон нийт зээлийн 7.8 хувь нь эргэн төлөгдсөн бол 92.2 хувь нь төлөгдөөгүй байгаа. Үүн дотроос улсын төсвөөс санхүүжүүлсэн төслүүдийн 3.2 их наяд төгрөгийн өр авлагын асуудал хүнд байгаа. Үүнээс гадна тусгай 16 том төслийн асуудал бий. Үүний дийлэнх нь Засгийн газрын баталгаагаар зээл олгогдон төрийн өмчит компаниудтай холбоотой. Хөгжлийн банкнаас энэ асуудалд тодорхой ажлын хэсэг гаргаж

ажиллуулахаар болсон. Энэ жилийн хувьд эргэн төлөгдөх өр авлагын хэмжээ бага байгаа. Найдваргүй зээлийн асуудал байгааг нь хууль хяналтын байгууллага руу шилжүүлж харууцлага тооцно” гэлээ.

*Хөгжлийн банкны талаар авах зарим арга хэлтээний тухай асуудалтай холбоотой гишүүдийн байр суурийг хүргэж байна.*

## УИХ-ын гишүүн Ө.Энхтүвшин:

“Хөгжлийн банкнийг эргээд харахад үр могой төрүүлсэн байна. Бүтэн нэг жилийн төсвийн орлоготой тэнцэх хэмжээний мөнгө үрэн таран хийсэн байна. Үүнийг нь ярих гэхээр зээлжих зэрэглэл буурна, адилхан хувааж идсэн уусан гэдэг зүйл ярьдаг. Хариуцлага гэдэг зүйлийг 65 суудалтай манай нам ярихгүй байгаа шүү. Хариуцлага гэдэг үгийг хэлж байгаа ч үйлдэл болохгүй байгаа шүү.”

## УИХ-ын гишүүн Ц.Даваасүрэн:

“Сая бид хаалттай хэлэлцэх гэж байгаад болилоо. Банк санхүүгийн асуудал мөнгө босгох тал дээр эх оронч үзэлтэй хандах цаг болсон байна. Өнөөдөр Хөгжлийн банкны өөрийн хөрөнгийг нэмэгдүүлээд дүрмийн санг нь нэмэгдүүлнэ гэж байна. Гэвч энэ банкны бодлого ямар чиглэлээр явах гээд байна вэ. Дахиад өмнөх шигээ бодлогогүй танил тал хараад явуулчих юм уу. Ямар ирээдүй харагдаж байна вэ?”

## Сангийн сайд Б.Чойжилсүрэн:

“Хөгжлийн банкны дүрмийн санг үе шаттай нэмэгдүүлэх асуудал оруулж ирсэн. Цаашид ямар бодлого баримтлах вэ гэж байна. Хаалттай хуралдах юм бол бүх тооцоо судалгааг хэлээд явах боломжтой. Хөгжлийн банкны санхүүжүүлэх зээл хүндэрсэн

учраас сан байгуулах шаардлагатай болоод байна.

## УИХ-ын гишүүн Ш.Раднаасэд:

“Зарчмын хувьд тогтоолын төслийг дэмжиж байна. Өр авлагын асуудлыг арванхоёрдугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгоод хаая гээд байгаа юм уу. Яарч сандарч энэ асуудлыг хэлэлцэх ямар шаардлага байна вэ? 3.2 их наяд төгрөг үнэн хэрэгтэй адилсан байна. Алдсан юмаа авч чадахгүй бол төр гэж суугаад яах юм бэ? Хөгжлийн банкны дэргэд эсвэл Монголбанкны дэргэд өр барагдуулах алба гэж байгуулах хэрэгтэй. Тэгэхгүй бол 3.2 их наяд төгрөгийн өр зээлийн асуудал энэ сараар тасалбар болоод алга болох вий. Б.Батбаяр даргаа өр авлагаа барагдуулж авах эрх өөрт чинь бий.”

## Сангийн сайд Б.Чойжилсүрэн:

“Хөгжлийн банкнаас өнгөрсөн жил 3.2 их наяд төгрөгтэй тэнцэх хэмжээний төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүжүүлсэн юм байна. Төсвөөс эргэн төлөх нөхцөлтэй санхүүжүүлсэн объектод аудитын дүгнэлт гаргуулах санал энэ тогтоолын төсөлд орсон байгаа.”

## УИХ-ын гишүүн О.Баасанхүү:

“Өмнөх парламентын үед МАН, МАХН, АН хамтарч төр барьсан. Тэр дундаа МАН, АН сангийн асуудлаа барьсан. Хөгжлийн банкны нөхцөл байдлыг хараад би гайхаад байна. Монголд зургаахан банк бий. Ам.долларын нийлүүлэлт хийгээд байхад яагаад ханш буурахгүй байгаа юм бэ. Тэр ам.долларууд хаана байна вэ? Ам.доллараа худалдаж аваад гадагш гаргахсан юм уу? Хоёрдугаарт, өр төлбөрүүдээ арванхоёрдугаар сарын 31-нээр хааж байгаа юм бол өр төлбөрүүдийг нь хэн төлөх юм бэ. Өр барагдуулах нэгж гэж

зохион байгуулалттай ажлын хэсэг байгуулах юм уу. Цаашид өр төлбөрүүд төлөгдөх юм уу, үгүй юу. Хөгжлийн банкны дээр ард түмний нэрийг бариад хууль зөрчсөн зүйл байгаа бол өмнөх Сангийн сайд нар хариуцаага үүрэх ёстой. Миний сонссоноор зээлийн 60 хувийг МАН авсан гэж байсан. Энэ зээлийг үнэхээр Монгол ардын намынхан авсан юм биш үү. Сонгуулийн сурталчилгааны үед хоёр намынхан онгоцоор нисч сурталчилгаа хийж байсан. Энэ их мөнгө хаанаас гарсан юм бэ?”

## Сангийн сайд Б.Чойжилсүрэн:

“Ам.долларын ханш яагаад буурахгүй байна вэ гэвэл өнгөрсөн жил тавьсан их өрийн дарамтад ороод байна. Өрийн асуудлаас болж төлбөрийн тэнцэл дарамттай байна. Тиймээс ам.долларын ханш буурч өгөхгүй байна. Өнгөрсөн дөрвөн жилийн хугацаанд долоон их наяд 954 тэрбум төгрөгийг мөнгө хэвлэж зах зээлд нийлүүлсэн байдаг. Үүнээс шалтгаалж ам.долларын хомсдол үүсээд байгаа юм. Өр төлбөрийн гүйцээж барагдуулах тал дээр хатуу арга хэмжээ авна. Ямар ч зээл өр тас алга болно гэж байхгүй.”

Ингээд “Монгол Улсын Хөгжлийн банкны талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэхийг УИХ-ын чуулганы хуралдаанд оролцсон гишүүдийн 69.4 хувь нь дэмжив. Харин УИХ-ын чуулганы баасан гарагийн үдээс хойших хуралдаанаар Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэлэлцэх эсэхийг хэлэлцээд, дэмжээгүй юм. Тиймээс хууль санаачлагч УИХ-ын гишүүн Т.Аюурсайханд хуулийн төслийг буцаалаа.

## МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ

## Хувь хүний орлогын албан татварын хуульд өөрчлөлт оруулах нь

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг УИХ-ын гишүүн С.Чинзориг санаачилж, хуулийн төсөлд санал авахаар Засгийн газарт хүргүүлжээ. Улмаар Засгийн газар хэлэлцээний дараа УИХ-д өргөн барих юм. Тэрбээр уг хуулийн талаар “Сүүлийн жилүүдэд эдийн засгийн өсөлт саарч, аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн чадавхи суларснаас цалин хөлс, хөдөлмөрийн орлого төдийлөн нэмэгдсэнгүй. Цаашид дорвитой нэмэгдэх хандлага ажиглагдахгүй байгаа нь иргэдийн, ялангуяа бага орлоготой хэсгийн

амьжиргаанд сөрөг нөлөө үзүүлж байгаа билээ. Иймд хувь хүний орлогын албан татварт үзүүлэх хөнгөлөлтийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдуулах замаар бодит орлого, худалдан авах чадварыг нэмэгдүүлэх зорилгоор уг хуулийн төслийг боловсруулсан” гэлээ. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль 2006 онд батлагдсан бөгөөд 2007 оноос хүчин төгөлдөр үйлчилж буй энэ хуулиар албан татвар төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод ногдох жилийн албан татварт 84 мянган төгрөгийн хөнгөлөлт үзүүлж байгаа юм. Үүнийг сард шилжүүлж тооцвол ердөө долоон төгрөг. Одоо мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг ирэх сарын 01-нээс 240 мянган төгрөг болж нэмэгдэнэ. Тиймээс хувь хүний орлогын албан татварт үзүүлэх хөнгөлөлтийн хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцүү байхаар



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

хуульчлан тогтоовол татвар төлөгч иргэн жилд 240 мянган төгрөг, сард 20 мянган төгрөгийн хөнгөлөлт эдлэх боломж бүрдэх юм байна.

## Үндсэн хуулийг өөрчлөх эсэхийг судлах баг ажилдаа оров

Монгол Улсын Үндсэн хуульд өөрчлөлт оруулах шаардлага үүссэн үү гэдгийг судлах Ерөнхий сайдын захирамжийн дагуу байгуулагдсан ажлын хэсэг өнгөрсөн баасан гарагт анхны уулзалтаа хийлээ. Уулзалтад Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга Ж.Мөнхбат, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд багтсан 15

гишүүн оролцсон юм. Уг ажлын хэсэг гурван сарын хугацаанд 21 аймаг, 330 сум, нийслэлийн есөн дүүрэгт ажиллах юм байна. Тэд олон нийт Үндсэн хуульд өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзэж байна уу, ямар асуудлын хүрээнд өөрчлөлт оруулах шаардлага үүссэн гэж үзэж байна вэ гэдгийг судалгаанд үндэслэн гаргаж ирэх аж. Мөн

ажлын хэсэг нь Засгийн газраас тодорхой чиглэл авахгүй, бие даасан үйл ажиллагаа явуулах юм байна.

Монгол Улс Ардчилсан шинэ Үндсэн хуулийг баталснаас хойш 25 дахь жилтэйгээ золгож байгаа. Энэ хугацаанд 15 Засгийн газар өөрчлөгдөж, мөн тооны Ерөнхий сайдыг УИХ-аас томилон ажиллуулсан нь насжилтын хувьд

богино байгаа гэнэ. Тодруулж хэлбэл, Засгийн газрын дундаж нас 1.7 жил байна гэсэн судалгаа гарчээ. Иймээс ч судлаачдын дунд Үндсэн хуульд өөрчлөлт оруулж, засаглалын хэлбэрээ илүү оновчтой боловсронгуй болгох шаардлага байна гэж үздэг болсон. Засаг захиргааны хуваарилалтаа эргэн харж, засахаас эхлээд олон асуудлыг

орчин цагийн хөгжилтэйгээ уяж өөрчлөхгүйгээр тулгарч байгаа бэрхшээлийг дэвэр туулах боломжгүй гэдгийг эрдэмтэн судлаачид сануулсаар байгаа аж. Олон нийтийн зүгээс Засгийн газарт хандан олон санал хүсэлт ирүүлдэг. Тиймээс дээрх ажлын хэсэгт эрдэмтэн судлаачид, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл багтаан байгуулжээ.

## ИРЦИЙН МЭДЭЭ

## Хамгийн залуу гишүүн Д.Гантулга ажлаас таслав

УИХ-ын Тамгын газраас арванхоёрдугаар сарын 23-ны өдрийн гишүүдийн ирцийн мэдээг гаргажээ. Өмнөх өдөр нь хурлаас таслаж, алга болсон С.Жавхлан гишүүн өнгөрсөн баасан гарагт 11.03 цагт чуулганы танхимд ирж, ирцэндээ орсон. Харин хамгийн залуу гишүүн болох Д.Гантулга ажлаас тасалжээ. УИХ-ын 76 гишүүнээс арав нь гадаадад томилолтоор, орон нутагт дөрвөн гишүүн ажиллаж байна. Чөлөөт таван гишүүн авчээ. Дашрамд дуулгахад, өнгөрсөн баасан гарагт 24 гишүүн 10.00 цагаас урьтаж ирцээ бүртгүүлсэн нь ойрд үзүүлээгүй амжилт боллоо.

**ММINFO**

**МОНГОЛЫН МЭДЭЭ**

19 дэх жилдээ

Ерөнхий эрхлэгч: **С.ГАНТОГОО**

Орлогч эрхлэгч: **Ч.ЧУЛУНЦЭЦЭГ 99189158**

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: **Э.ЭНХЦЭЦЭГ 90873012**

Ахлах редактор: **Б.ӨНӨРТОГТОХ 88006842**

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба: **Н.ПУНЦАГБОЛД 88096454**

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: **Б.ӨНӨРТОГТОХ 88006842**

Гэрэл зургийн алба: **Г.АРГУУЖИН 96017873**

Компьютерийн алба: **Б.ГАНЗОРИГ 99998796**

Маркетинг, зар сурталчилгааны алба: **Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710**

Захиалга, борлуулалтын алба: **М.ДАВААДУЛАМ 99042510**

**Э.САЙНЗАЯА 99197866**

Дугаарыг эрхлэсэн **Э.ЭНХЦЭЦЭГ**

Улсын бүртгэлийн дугаар: 907300528  
Индекс: 100757

Редакцийн хаяг: **Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/, 2 давхар, 209, 211 тоот**

Харилцах утас, факс: **976-70113551**

“Монголын мэдээ” сонины редакцид эхийг бэлтгэж, “Чөлөөт хэвлэл сан”-ийн хэвлэл үйлдвэрт хэвлэв.

ҮЗЭЛ БОДОЛ

2017 ОНД БИДНИЙГ ЮУ ХҮЛЭЭЖ БАЙГАА ВЭ

Дугаарын 60 мөр

Аль хэдийнэ л цахилгааны шөнийн тарифыг тэглэх байсан юм

Төгсгөл. Түрүүч нь I нүүрт

Утаанаас салахын тулд орон сууцжуулах шаардлагатай. Түүнээс өмнө яаралтай арга хэмжээ авч, утааны хорыг ч болов багасгах хэрэгтэй. Ингэхийн тулд утаагүй зуух, утаагүй түлш тараахаас өөр аргагүй хэмээн иргэдийн тархийг угаасан. Саяхныг болтол жилдээ 30 тэрбум төгрөгийг утаагүй зуух үйлдвэрлэх, түлш хийх энэ тэрд үрэн таран хийж байсан шүү дээ. Үе үеийн Засгийн газар ажилласан нь үнэн. Гэхдээ үр дүнд огт хүрээгүй байна. Харин ч утаа улам ихэссээр. Угаасаа гэр хороолол улам тэлж, автомашины тоо өдрөөс өдөрт нэмэгдэж байхад яаж утаанаас салах вэ дээ. Харин өнгөрсөн долоо хоногт Ерөнхий сайд гэнэт ухаан орж, гэр хорооллын иргэдийн цахилгааны шөнийн тарифыг тэглэхээр боллоо. Тэрбээр "Утаа багатай зуух, утаа багатай түлш л үйлдвэрлэж байж. Зуух ч утаа гаргана, түлш ч утаа гаргана. Тийм учраас агаарын бохирдол буурахгүй байна.

Ганц түлш, зуухтай ноцолдоод ямар ч үр дүн үзүүлэхгүй байна. Тиймээс өнөөдөр Улаанбаатарын утаа ийм хэмжээнд хүрч, нийгэмд бухимдал үүсээд байна" хэмээн хэлсэн. Өнөөдрийг болтол нэг ч Ерөнхий сайдын ойлгоогүй байсан зүйлийг энэ хүн ойлгосонд баярлаад барахгүй байна. 2017 онд агаарын бохирдлыг бууруулахад зориулж дөрвөн тэрбум төгрөг төсөвлөсөн. Энэ мөнгөний 80 хувийг шөнийн тарифыг тэглэхэд зарцуулах юм байна. Одоо л зөв ажиллаж эхэллээ. Аль эрт л ингэх байсан юм. Бүр жилдээ 30 тэрбумыг хайр найргүй үрж байхдаа л энэ аргыг хэрэглэх байлаа.

Тэгээд шөнийн тарифыг хөнгөлсөн алдагдлыг нь цахилгаан станцуудад өгөөд, илүү гарсан мөнгөөр нь шалны халаалтаас авахуулаад цахилгаанаар халааж болох бүх л технологийг нэвтрүүлэх байсан юм. Тэр бүгдийг хөнгөлөлттэй үнээр өгөхөд төсвөө зарцуулсан бол бид өдийд утаанаас салчихдаггүй юм гэхэд хөнгөлчихсөн байх байлаа. Гэхдээ оройтсон ч гэсэн ийм шийдвэр гаргасан нь их юм даа. Хэдийгээр манай улсын цахилгаан эрчим хүчний чадал тийм ч сайн биш ч гэсэн гэр хорооллын 200 мянган айлын ядаж 10 хувь нь яндангаасаа салчихвал сайн хэрэг биз дээ. Нэг үеэ бодвол 3, 4 дүгээр цахилгаан станцууд өргөтгөл хийчихсэн. Цахилгаан эрчим хүчний чадал арай дээрдээд л байгаа. Цаашлаад Ерөнхий сайд эрдэмтэдтэй хамтарч ажиллахаар болоод, цахилгаан эрчим хүчний хэмнэлттэй халаалтын системийг шийдэхээр болсон байсан. Цахилгаан бага хэрэглэдэг, дээрээс нь гэр, байшинг хангалттай халаагаад байдаг халаалтын систем гаргаад ирвэл бүр ч болоод явчихлаа. Одоо ч гэсэн халаалтын түмэн янзын технологи гарчихсан байна. Гагцхүү цахилгааны үнийг нь дийлэхгүй гээд л иргэд хэрэглэхгүй байгаа болохоос биш. Одоо бол шөнийн тарифыг хөнгөлчихлөө. Иргэдэд ч боломж гараад ирлээ. Цаашлаад утаа бууруулахад зориулах олон тэрбумаа цахилгаан халаалтын төхөөрөмжүүдийг хөнгөлөлттэй үнээр авахад зарцуулбал сайнсан. Энэ Засгийн газар утааны эсрэг зөв ажил эхлүүллээ. Цаашлаад энэ замаасаа гарчихалгүй явах байлгүй дээ.



Төгсгөл. Түрүүч нь I нүүрт

А-Н-ын хувьд Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшиж байгаа хүн нь нэг их сүртэй сурталчилгаа хийгээд байх шаардлага байхгүй. МАН-ынхан юу хийж байгааг хараад, алдаан дээр нь түлхчихээд байж байхад л болно. Харин эрх баригчид хазгай гишгэж, хажуугаасаа түлхүүлэхгүйн тулд энэ улсын эдийн засгийг дээшлүүлж, эх орноо өөд нь татах том даалгавартай үлдлээ. Юуны өмнө гадаад өрөө яаж төлөх вэ гэдэг асуудал байна. Зөвхөн 2017 он гэлтгүй 2018 он ч байна. 2018 онд эдийн засаг улам хэцүүдэх төлөвтэй байгаа талаар эдийн засагчид яриад байгаа. Энэ бол чухам үнэн. Тийм болохоор 2017 онд дарах өрөө хэн нэгнээс эзэлээд, гуйж гувшиж байгаад дарчихлаа гээд санаа амрах болоогүй. Тийм болохоор эрх баригч намынхан, тэр дундаа Ерөнхийлөгч болох хүсэлтэй байгаа л бол энэ намын дарга хамгийн зөв гарцыг олж хямралаас гарах шаардлагатай байна. Ер нь бол эдийн засгийг сайжруулж, асуудлыг шийдэх нь тодорхой байх. Тэгж байж Ерөнхийлөгчийн сонгуульд хэлэх үгтэй орно. Харин гагцхүү яаж. Одоогоор бидэнд нэг их сайхан гарц харагдахгүй л байна. ОУВС-гаас авах зээлийг хүлээсэн байдалтай байгаа. Зарим хэвлэлээр ОУВС манайд зээл өгөх нь тодорхой боллоо, харин хэдийг бол гэсэн мэдээлэл гараад байсан.

..том төслүүдээ хөдөлгөж, бүх зүйлээ гаднаас авдаг биш өөрсдөө үйлдвэрлэдэг улс болох шаардлага ч байна. Энэ бүхнийг хийж чадаж байж л эрх баригчид нэр хүндээ аварч үлдэнэ. Ерөнхийлөгчийн сонгуульд далаараа тавиулчихалгүй үлдэнэ. 2017 онд биднийг арай ч цалин, тэтгэврээ тавьж чадахгүй Засгийн газар хүлээж байгаа гэж бодохгүй байна. Тэд одоо өөрийнхөө эрх ашгаас арай жаахан илүүтэй улс орны асуудлыг тавьж байгаа байх...

Гэтэл хамгийн сүүлд Монголбанкны Ерөнхийлөгч ОУВС-тай хийж байгаа

хэлэлцээр үргэлжилж байна гэж ярьсан байна билээ. Он гарч байж л нааштай мэдээ дуулдах байх. Эсвэл наашгүй мэдээ. Манай эрх баригчид Хятадын Засгийн газрын өмнө бүгдээрээ өвдөг сөхрөх нь холгүй юм болоод байгааг бодохоор ОУВС-гийн зээл бүрхэг болчихсон юм биш биз дээ гэж санаа зовохоор байна. Дээрээс нь Хятадаас ямар ч аргаар хамаагүй зээл авах гээд ч байх шиг. Гадаад өрөө дарж, эдийн засагт хэдэн ам.доллар оруулж ирж л байвал юу ч хамаагүй хийж гэж "чичрээд" байгаа юм биш биз гэж хардахаар л байгаа. Цаашлаад давхар иргэншил, Далай ламыг дахиж Монголд оруулахгүй гээд асуудал мундахгүй байна. Яах вэ, эрх баригчид эхлээд "гал"-аа унтраачихаад, дараань өндийж босох ажлаа эхэлж гэж байж ч болох. Уг нь манай улс Оюутолгой, Тавантолгойгоо л зөв хөдөлгөчихсөн байсан бол амаараа шороо үмхэх дээрээ тулчихгүй байсан. Тавантолгойг хөдөлгөх асуудал одоо ч шийдэгдээгүй хэвээрээ байсаар байгаа. Саяхнаас л ганц нэг уулзалт энэ тэр хийж, урагшуулах асуудлыг ярьж эхэлсэн. Ерөөсөө "сэхээнд орчихсон" эдийн засгаа ухаан оруулж аваад, цаашд өөрсдөө лэмчлэх шаардлагатай. Түүнээс биш гаднаас зээл аваад, түүгээрээ эдийн засгаа эмчлээд явна гэж угаасаа байхгүй. Өөрсдөө "эмчлэх"-ийн тулд энэ хэдэн том төслүүдээ хөдөлгөх, олсон мөнгөө улс орондоо зөв

зарцуулахаас өөр арга эрх баригчдад үлдсэнгүй. Тэр битгий хэл эдэнд шинэ жил тэмдэглэх ч эрх үлдээгүй шүү дээ. Тийм мөнгө ч манай улсад байхгүй. Одоо бүх зүйлээ хэмнэж байж л хөл дээрээ босно. Хөл дээрээ босоод цаашид гуйвахгүй алхах хэрэгтэй болно. Тиймээс том төслүүдээ хөдөлгөж, бүх зүйлээ гаднаас авдаг биш өөрсдөө үйлдвэрлэдэг улс болох шаардлага ч байна. Энэ бүхнийг хийж чадаж байж л эрх баригчид нэр хүндээ аварч үлдэнэ. Ерөнхийлөгчийн сонгуульд далаараа тавиулчихалгүй үлдэнэ. 2017 онд биднийг арай ч цалин, тэтгэврээ тавьж чадахгүй Засгийн газар хүлээж байгаа гэж бодохгүй байна. Тэд одоо өөрийнхөө эрх ашгаас арай жаахан илүүтэй улс орны асуудлыг тавьж байгаа байх. Ерөнхийлөгчийн сонгууль, гадаад өр, улсын эдийн засаг гээд бүх зүйл нэг сэжмээр холбогдож байгаа. Гадаад өрөө асуудалгүй дарж, эдийн засаг бага ч болов сэргэж байж Ерөнхийлөгчийн сонгуулийн талаар ярих байх. Түүнээс өмнө эрх баригчдад хийх ажил их байна даа.



МОНГОЛЫН МЭДЭЭ
Манай сонины Гууирлын захиалга яваглаж байна
Захиалгын үнэ 22400₮
Монгол шуудан: 7007877
УБ шуудан: 70127027
Сайт рорт: 70121284
Түгээмэл шуудан: 70151025

ӨНӨӨДРИЙН ТОП ИШЛЭЛ

“Ооооөөеéí ààðàì ò òçì ýí îëîíá òàíààèòòàé ààéàà. Ààòèàà ààðàì òèàò òýðýààçé. Ààààà 1200 ò-ò-èèá à÷ààá á°í ðì áíèæ áàéíà. Ñàì àð÷ áàéíà. Ò°ò°ò °àèèèéí òçéòýíä ò-ò-àçé áíèñíí íèðäýä óéèæ áàéíà.”



Угчх-ын гишүүн, С. Жавхлан

Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

# ДЭЛХИЙ

## Дэлхийн хамгийн өндөр хөшөө Энэтхэгт сүндэрлэх нь

Энэтхэгийн Ерөнхий сайд Нарендра Модри дэлхийн хамгийн том хөшөөг эх орондоо босгохоор зэхэж, тулгын чулууг нь тавьжээ. Тус улсын баруун этгээдийн Мумбайн эрэгт байрлах аралд Н.Модри Чхатрапати Шиваджи хааны хөшөөг босгох гэж буй бөгөөд саяхан шавьг нь тавьсан байна. Уг хөшөө баригдсанаар дэлхийн хамгийн өндөр, том хөшөө болон сүндэрлэх гэнэ. Чхатрапати Шиваджи 17 дугаар зууны үед Исламын Их Моголын эзэнт улстай дайтаж, Маратагийн эзэнт улсыг байгуулж явсан баатарлаг удирдагч аж. Шиваджигийн хөшөөг 192 метр өндөртэй барихаар төлөвлөж буй бөгөөд ингэснээр АНУ-ын Нью-Йорк хотод байрлах Эрх чөлөөний хөшөөнөөс хоёр дахин өндөр, Бразилын Рио де Жанейро хотын Христийн хөшөөнөөс тав дахин өндөр болно гэдгийг албаныхан мэдээлж байна.



Өнөөдрийн байдлаар дэлхийн хамгийн өндөр хөшөө БНХАУ-д байрладаг ажээ. Тодруулбал, 128 метр өндөр Буддагийн хөшөө тус улсын Хэнань мужид байрладаг юм. Тэгвэл 192 метр өндөр Чхатрапати Шиваджигийн хөшөө боссоноор энэ амжилтыг эвдэж дэлхийн хамгийн өндөр хөшөө болон сүндэрлэх гэнэ. Хинди шашинтнуудын гол төлөөлөгч Ерөнхий сайд Нарендра Модри тэргүүтэй хүмүүсийн олон жилийг зориулсан томоохон хэмжээний төсөл нь энэ бөгөөд Мумбайн эрэг дэх Арабын тэнгисийн дунд орших арал дээр Чхатрапати Шиваджигийн хөшөө сүндэрлэх аж.

Харин бүтээн байгуулалтын ажилд 36 тэрбум рупи төсөвлөснөөс гадна 2019 он гэхэд бүрэн ашиглалтад орох гэнэ. Гэвч Засгийн газар ийм хэмжээний хөрөнгийг зүгээр нэг хөшөө барихад зарцуулахын оронд дэд бүтэц, боловсрол, улс орны хөгжил цэцэглэлтэд зориулах хэрэгтэй хэмээн тус төслийг эсэргүүцэгчид олон байна. Тэдний хувьд "change.org" гэх гарын үсэг цуглуулах сайтыг байгуулж, Шиваджигийн хөшөөний бүтээн байгуулалтын ажлыг даруй зогсоохыг шаардаж болжээ. Одоогоор энэ хөдөлгөөнд 27 мянган хүн нэгдэж гарын үсгээ зурсан байна. Эсэргүүцэгчид "Хөшөөнд зарцуулагдсан мөнгө хог болоод дуусахаас хэтрэхгүй, бас байгаль орчин Мумбайн өмнөд хэсгийн авто замд сөрөг нөлөө учруулна" гэж үзэж буй гэнэ. Энэтхэгийн Гужарат мужид ч гэсэн Энэтхэг улс тусгаар тогтносны дараа хамгийн анх Ерөнхий сайдаар томилогдож байсан Сардар Пателын хөшөөг мөн босгохоор ажиллаж буй юм. Хөшөөний барилгын ажил 2014 онд эхэлсэн бөгөөд 182 өндөр хөшөө болон сүндэрлэх учиртай. Уг барималд 25 тэрбум рупи төсөвлөсөн байдаг билээ.

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



## ОРОСЫН TU-154 ОНГОЦ ХАР ТЭНГИСТ ОСОЛДЛОО

Б.ДАВААХҮҮ

ОХУ-ын цэргийн нисэх хүчний Ту-154 онгоц орон нутгийн цагаар очигдөр өглөө 05:20 цагийн үед Хар тэнгисийн аялал жуулчлын Сочи хотоос Сирийн Латакия дахь тус улсын агаарын цэргийн баазыг чиглэн нисчээ. Гэвч хөөрснөөс хойш 20 минутын дараа радарын дэлгэцээс алга болж, сураггүй болсон бөгөөд Батлан хамгаалах салбарынхан Хар тэнгист хайхаар эрлийн багийг илгээгээд байв. Тус онгоцонд нийтдээ 92 хүн зорчиж явжээ. Тэдний дийлэнх нь ОХУ-ын алдартай цэргийн "Александра Ансамбль"-ийнхан байсан бол ес нь нисэх багийн гишүүн байсан аж. Мөн зарим эх сурвалжийн мэдээлж буйгаар есөн сэтгүүлч зорчиж явсан байна. Цэргийн чуулгын

...Онгоцны сүйрлийн шалтгаан тодорхойгүй. Гэхдээ ОХУ-ын Мөрдөх товчоо техникийн доголдол, эсвэл нисгэгчийн буруутай үйлдлийн улмаас сүйрсэн эсэхийг тогтоохоор хяналт шалгалтын ажлаа эхлүүлжээ...

уран бүтээлчид Сири дэх ОХУ-ын цэргийн баазад очиж, шинэ жилийн баярын тоглолт зохион байгуулахаар ийн хөөрсөн ч

сураггүй болсон байна.

Онгоц радарын дэлгэцээс алга болмогц онц байдал зарлан хайх ажиллагаа эхэлжээ. Тэгвэл удалгүй онгоцны хэсгийг Сочи хотын эргээс 1.5 км зайд Хар тэнгисийн 50-70 метрийн гүнээс олсон байна. Ту-154 онгоц нь ЗХУ-ын үеийн гурван хөдөлгүүрт агаарын хөлөг юм. Өмнө нь 2010 онд энэ загварын онгоц сүйрч, дотор нь зорчиж явсан Польшийн Ерөнхийлөгч Лех Качински таалал төгссөн байдаг. 2015 оны есдүгээр сараас хойш Москва Сирийн Ерөнхийлөгч Башар ал Ассадыг дэмжин Сирийн босогчдын эсрэг агаараас цохилт өгч эхэлсэн байдаг. Одоогийн байдлаар Сирийн армитай хүч хавсран Алеппо хотыг хэт даврагчдаас чөлөөлөхөөр агаараас цохилт өгч байгаа юм. Кремлийн төлөөлөгч Дмитрий Песков

ослын талаар мэдэгдэл хийхдээ нөхцөл байдлын мэдээллийг В.Путинд шуурхай танилцуулж буйгаа илэрхийлсэн байна. Онгоцны сүйрлийн шалтгаан тодорхойгүй. Гэхдээ ОХУ-ын Мөрдөх товчоо техникийн доголдол, эсвэл нисгэгчийн буруутай үйлдлийн улмаас сүйрсэн эсэхийг тогтоохоор хяналт шалгалтын ажлаа эхлүүлжээ. Хамгийн сүүлд авсан мэдээллээр онгоцыг хөөрөхөд бэлтгэх үүрэгтэй ажилтнуудыг шалгаж эхэлсэн байна.

Аврагчид ослын бүсээс нэг хүний цогцыг илрүүлсэн байх хэдий ч, амьд хүн байгаа эсэх талаар ямар ч мэдээлэл байхгүй байна. Нэрээ нууцалсан эх сурвалжийн "Интерфакс" агентлагт өгсөн мэдээллээр онгоц радарын дэлгэцээс алга болохын өмнө ямар нэг дохио ирүүлээгүй гэнэ.

## ЭРДЭМТЭД "ТУСГААР ТОГТНОЛ БА ГАДААД БОДЛОГО" СЭДВЭЭР ХУРАЛДАВ



Гэрэл зургийг Г.АРИУНБОЛД

Н.БАТЗАЯА

Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны болон орчин үеийн дипломат алба үүсч хөгжсөний 105 жилийн ойд зориулсан "Тусгаар тогтнол ба гадаад бодлого" сэдэвт эрдэм шинжилгээний бага хурал өнгөрсөн баасан гарагт Гадаад харилцааны яамны "Зөвшилцөл" танхимд боллоо. Энэхүү хурлыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Монгол Улсын Гадаад харилцааны яам хамтран зохион байгуулсан юм. Хурлыг нээж, УИХ-ын гишүүн, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Ж.Энхбаяр хэлэхдээ "Орчин үед дэлхий нийтээр даяаршиж, шинжлэх ухаан, мэдээллийн технологи хөгжиж, улс орнуудын харилцан хамаарал ихээхэн гүнзгийрэх боллоо. Монгол Улсын гадаад бодлого нь Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал болон бусад бичиг баримтад тулгуурлан дэлхийн улс орнуудтай найрсаг харилцаатай байж, улс төр эдийн засгийн болон бусад салбарын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататгахад чиглэж байна. Үүний дотор бид Монгол Улсын аюулгүй байдал, үндэсний язгуур эрх ашгийг олон улсын эрх зүйн хүрээнд улс төр, дипломатын аргаар хангахыг гадаад бодлогынхоо тэргүүлэх чиглэл болгон ажиллаж байна. Дайн, зэвсэгт мөргөлдөөн, хүний болон хар тамхины наймаа, гоц халдварт өвчин, цаг уурын өөрчлөлт, байгаль орчны доройтол зэрэг хүн төрөлхтөнд заналхийлэх аюулын эрсдэл, сорилтын хүрээ нэмэгдсээр байна. Тиймээс Монгол Улс төрийн алтан аргамж буюу олон зуун жилийн түүхэн уламжлал

бүхий дипломат албаныхаа үүрэг гүйцэтгэх чадварыг цаг үетэйгээ нийцүүлэн хөгжүүлэх шаардлага тулгараад байна.

Үүний тулд бид Үндсэн хуульд дорвитой өөрчлөлт хийж, гадаад бодлогоо төгөлдөржүүлэх хэрэгтэй. Энэ зорилгыг хэрэгжүүлэхэд эрдэмтэн судлаачид, мэргэжлийн хүмүүсийн санаа бодол, зөвлөмж ихээхэн ач холбогдолтой" гэв. Тус хурлын үеэр эрдэмтэд илтгэл тавьж, хэлэлцүүлэг өрнүүлсэн юм. Тухайлбал, "Монгол Улсын тусгаар тогтнол ба ХХ зууны эхэн үеийн олон улс болон бүс нутгийн нөхцөл байдал" илтгэлийг МУИС-ийн багш, доктор Г.Төмөрчулуун, "Богд хаант Монгол Улсын дотоод улс төр, нийгэм, эдийн засгийн байдал" илтгэлийг доктор О.Батсайхан, "Богд хаант Монгол Улсаас тусгаар тогтнолоо бусад улсуудаар хүлээн зөвшөөрүүлэхээр авч хэрэгжүүлсэн үйл ажиллагаа" илтгэлийг доктор Т.Төмөрхүлэг тавьсан. Мөн "XXI зууны эхэн үеийн Монгол Улсын орчин, нөхцөл байдал" илтгэлийг Стратеги судлалын хүрээлэнгийн

захирал Д.Ганбат тавьж, илтгэлийн хүрээнд хэлэлцүүлэг өрнүүлсэн юм. Түүнчлэн хурлын үеэр тавьсан илтгэлүүдэд сонирхолтой тоо, баримт дурдагдаж байсныг эрдэмтэд онцоллоо. Энэ үеэр хуралд оролцсон эрдэмтэн болон холбогдох албаны хүмүүстэй уулзаж, цаг үеийн асуудлаар байр суурийг нь сонслоо.

А.Пүрэвсүрэн:  
Монголын төр хэзээ ч Далай ламыг урьж байгаагүй

/Монгол Улсын  
Ерөнхийлөгчийн Гадаад  
бодлогын зөвлөх/

-Саахалт хүний санаа нэг, айл хүний амь нэг гэдэг шиг бид хөршгүйгөө найрсаг амьдрах ёстой. Ямар ч улс орон хөршгүйгөө найрсаг харилцаатай тогтоон нийгэм, эдийн засгийн байдлаа зорьдог. Тиймээс бид эндээс нүүгээд явчихгүй учраас Монгол Улсын гадаад бодлогын

тэргүүлэх зорилго нь хоёр хөрштэйгөө найрамдалт харилцаатай байх явдал юм. Яах вэ, Далай ламын айлчлал болсон. Монгол Улсын төрийн байр суурь маш тодорхой.

Монголын төр хэзээ ч далай ламыг урьж байгаагүй. Бид нөгөө талаас ардчилсан улс. Шашны байгууллага өөрийнхөө шугамаар сүсэгтэн оныхоо хүсэлтээр Далай ламыг урьдаг. Одоогийн байдлаар дэлхий дээр ганцхан Далай ламыг шашныхаа тэргүүн гэж үздэг тусгаар эрдэмтэн нь Монгол орон байх шиг байна. Тийм учраас Далай ламын айлчлал нэлээд онцлог байдаг. Өмнө нь найман удаа ирж байсан. Тухайн үед ч тийм асуудал гарч байсан. Гадаад харилцааны сайдын хийсэн мэдэгдлийн талаар надад ойлголт алга. Өөрөө мэдэгдлийнхээ талаар тайлбар хийх байх. Би хөрш оронтойгоо эвсэг харилцаатай байх ёстой гэдэг үүднээс Гадаад харилцааны сайд мэдэгдлээ хийсэн байх гэж бодож байна.

Я.Ариунболд: Гадаадад төрсөн монгол иргэдээ бүртгэх тухай асуудал

/ГХЯ-ны Консулын газрын захирал/

-Гадаад харилцааны яамнаас өнгөрсөн есдүгээр сард гадаад суугаа монголчуудад зориулан давхар харьяаллын асуудлаар хурал зохион байгуулсан. Тэр хурлын үеэр бид нэг зарчмыг дэвшүүлсэн юм. Энэ нь Монгол Улсын харьяатын тухай хуулиар Монгол Улсын иргэнээс төрсөн хүүхэд дэлхийн хаана ч байсан Монгол Улсын

иргэн байна гэсэн зарчим юм. Манай улсын Бүртгэлийн тухай хуулиар Монгол Улсын иргэнээс төрсөн хүүхдийг 30 хоногийн дотор бүртгэнэ гэсэн хуулийн заалттай. Мөн Үндсэн хуульд Монгол Улс иргэнээ хасгахгүй гэж заасан байдаг. Манай улсын иргэд 1992 оноос гадаадад суурьших болсон. Үүнтэй холбогдуулан бид судалгаа хийж үзэхэд гадаадад 140 гаруй мянган иргэн амьдарч байна.

Мөн гадаадад монгол аав, ээжтэй 2181 хүүхэд төрсөн. Эгдэстэн нь Монгол орон байх шиг байна. Тийм учраас Далай ламын айлчлалтай байх ёстой. Энэ хүүхдүүд бол өөрөө төрөх орноо сонгож төрөөгүй. Аав, ээжийнхээ амьдарч байгаа газраас шалтгаалаад иргэншил нь тогтоогдсон. Гадаадад амьдарч, сурч байгаа Монгол Улсын иргэн давхар нэг үүрэг хүлээж байдаг. Аливаа улсын нутаг дэвсгэрт байгаа бол тухайн улсынхаа хуулийг хүндэтгэх ёстой болдог. Мөн харилцан адил байх зарчмын дагуу гадаадын иргэн манай улсад ирсэн бол Монгол Улсын хуулийг хүндэтгэх ёстой. Тэгэхээр манай улсын иргэд оршин суух улсдаа ажиллах, сурах гэх мэтчилэн статусын дагуу бүртгүүлдэг. Мөн дөнгөж төрсөн хүүхдэд эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэхийн тулд тухайн улсынхаа хуулиар иргэн нь болдог. Тэгэхээр өөр улсад төрсөн гээд Монгол Улсын иргэнээр бүртгэхгүй гэх нь болохгүй байна гэдэг асуудлыг хэлэлцэж байна. Давхар иргэншилтэй холбоотой зарим хүмүүсийн ярьж байгаа зүйлийг мэдэхгүй. Иргэдийн дунд гадаадын иргэд давхар манай улсын иргэншил авна гэх яриа гарсан. Энэ талаар бид мэдэхгүй.

ЦАГ ҮЕ

ТОМИЛОЛТ



ЭТҮҮИ

Улаанбаатар хотоос 200 гаруй км зайд орших Говьсүмбэр аймгийг зорин, энэ сарын 22-ны өдөр хүлгийн жолоо заллаа. Учир нь энэ өдөр Говьсүмбэр аймгийн Засаг дарга Г.Батсуурь 2016 онд авч хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, хэрэгжүүлэхээр батлуулсан бодлогын баримт бичгүүд, цаашид хийхээр төлөвлөж буй ажлуудаа нутгийн зон олондоо тайлагнаж, тэднийхээ санаа бодлыг сонссон юм. Өнгөрсөн удаагийн сонгуулиар Говьсүмбэр аймагт МАН үнэмлэхүй ялалт байгуулсан билээ. Үүний үр дүнд нутгаа мэддэг, нутгийн зон олныхоо хүсэл сонирхлыг арван хуруу шигээ ойлгодог удирдлагуудтай болсондоо иргэд ч сэтгэл хангалуун байгаа нь илт мэдрэгдэж байв. Ингээд аймгийн Засаг даргын иргэдтэйгээ хийх уулзалт “Боржигин” чуулгын танхимд эхэлж, Засаг дарга Г.Батсуурь илтгэл таавсан юм. Тэрбээр нутгийн зон олныхоо амар мэндийг эрэн мэндчилээд аймгийн төвч танилцуулга, төрийн байгууллагуудын танилцуулга, баримталж буй бодлого шийдвэрүүд, айлчлал, гэрээ хэлцэл, зохион байгуулсан арга хэмжээ, хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, цаашид хийхээр төлөвлөж буй ажлуудаа танилцууллаа.

# ИРЭЭДҮЙДЭЭ ИТГЭЛТЭЙ БАЙГААГАА ИЛЭРХИЙЛЛЭЭ

–Аймгийн Засаг дарга Г.Батсуурь иргэдтэйгээ уулзаж, хийсэн ажлаа тайлагнаж, хийх ажлаа зөвшилцөв–

**Г.Батсуурь:** Та бүхэнтэй ирээдүйд хийхийн тухай яривал их зүйл байна

*/Говьсүмбэр аймгийн Засаг дарга/*

–Манай аймаг 1991 оны УИХ-ын 46 дугаар тогтоолоор Дорноговь аймгийн Сүмбэр сум, Шивээговь хороо, Улаанбаатар хотын Баянтал хороог нэгтгэн улсын зэрэглэлтэй хот болоод дараа нь УИХ-ын 1994 оны тавдугаар сарын 06-ны өдрийн 32 дугаар тогтоолоор Чойр хотын хилийн цэсээр Говьсүмбэр аймаг болж байгуулагдсан. Хойд талаараа Төв аймгийн Баянцагаан, Баян, Баянжаргалан сумдтай зүүн ба зүүн хойд хэсгээрээ Хэнтий аймгийн Дэлгэрхаан, Дархан, Бор-Өндөр сумдтай, баруун болон баруун өмнөд хэсгээрээ Дундговь аймгийн Баянжаргалан, Цагаандэлгэр, өмнө талаараа Дорноговь аймгийн Даланжаргалан сумд зэрэг дөрвөн аймгийн есөн сумтай хиллэж, 5.5 мянган км<sup>2</sup> газар нутгийг эзэлдэг. 2015 оны жилийн эцсийн байдлаар аймгийн нийт хүн ам 16308, өрх 4987-д хүрсэн нь өмнөх оны мөн үеэс хүн ам 417 буюу 2.6 хувиар, өрх 238 буюу 5.0 хувиар өссөн үзүүлэлт юм. Мөн 2015 онд 379477 толгой мал тоолуулсан. 2016 оны жилийн эцсийн хүн ам, мал, тэжээвэр амьтны тооллого энэ сарын 01-ны өдрөөс эхэлсэн бөгөөд одоогоор 90 хувьтай явагдаж байна. Бид ажил аваад таван сарын хугацаа өнгөрлөө. Энэ хугацаанд аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн эдийн засаг нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлүүдийг боловсруулан, АИТХ-ын 2016 оны арваннэгдүгээр сарын 30-ны өдрийн хуралдааны 04, 05 дугаар тогтоолоор батлууллаа. Архи согтууруулах ундааны тусгай зөвшөөрлийг хуулийн хүрээнд олгож, хяналт шалгалтын давхардлыг багасгах зорилгоор аймгийн ИТХ-ын “Аймгийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох журам”-ыг батлууллаа. Энэ мэтчилэн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах зорилгоор есөн

дэд хөтөлбөрийг шинээр боловсруулан аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдээр батлуулсан бөгөөд хуучин хэрэгжиж байсан Иргэдийн экологийн боловсролыг дээшлүүлэх дэд хөтөлбөр, Аймгийн гадаад харилцааг салбараар хөгжүүлэх хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж ажиллана. Мөн манай аймаг аялал жуулчлалын салбарыг хөгжлийн тэргүүлэх чиглэл болгож байгаа. Олон мянган гадаад харилцааг салбараар хөгжүүлэх хөтөлбөрийг мөнгө баряг зарцуулахгүйгээр орлогоо нэмэгдүүлэх боломж гэж бид харж байна. Гэхдээ бидэнд нэг асуудал байгаа нь гадныхан ирэхэд буудал, 00-ийн асуудал маш хүнд байна. Энэ асуудлыг шийдвэрлэх хэрэгтэй байна. Үндсэндээ аялал жуулчлалын салбарыг хувийн хэвшил авч явдаг тул энэ салбарт бид онцгой анхаарч ажиллахаар төлөвлөж байна. Мөн биднийг ажил авснаас хойш гадаадын хоёр Элчин сайд, монгол төрийн хоёр сайд манай орон нутагт албан ёсны айлчлал хийлээ. Айлчлалын үеэр сонгуулийн үр дүн болон ирээдүйн төлөвлөгөө, гадаадын хөрөнгө оруулалт, авлигын эсрэг авч хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, иргэдийн нийгмийн байдал, Энхтайвны корпусын 25 жилийн ойн баяр, ирээдүйд хамтарч ажиллах боломжуудын талаар харилцан санал бодлоо солилцлоо. Манай аймагт Мянганы сорилтын сангийн гурван төсөл амжилттай хэрэгжсэн бөгөөд МСС-ний санхүүжилтээр Политехник коллеж дээр хэрэгжүүлсэн мэргэжлийн боловсролын төслийн үр дүнтэй би биеэрээ очиж танилцлаа. Мөн тус сангаас оруулсан бодит хөрөнгө оруулалтын ашиглалт, хамгаалалт маш сайн байсныг энд онцлон тэмдэглэе. Мөн Онцгой байдлын газарт очиж, тус газрын ажлын албатай уулзаж, тэдний ажил байдалтай танилцсан. Түүнчлэн “Шивээ-Овоо”-гийн ордыг түшиглэн 9240 мегаваттын хүчин чадалтай цахилгаан станцын төслийн гэрээ хэлэлцээр төгсгөлийн шатандаа орсон, удахгүй хөрсөн дээр буусан их бүтээн байгуулалт эхэлнэ гэдэгт итгэлтэй байна. Энэ нь одоогоор суурилагдсан хүчин чадалаас найм дахин өндөр

хүчин чадалтай болох бөгөөд дэлхийд хамгийн том нүүрсээр ажиллах цахилгаан станц болох юм гэдгийг онцлон тэмдэглэж, цаашид зам тээвэр болон бусад салбарт хамтран ажиллахаа илэрхийллээ. БНХАУ-ын Эрээн хотод зохион байгуулсан “Монгол, Хятад, Орос гурван улсын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааны чуулга уулзалт-2016”, үзэсгэлэн худалдаа, Шилийн хотод зохион байгуулсан гурван орны эдийн засгийн форумд оролцлоо. Тусчуулгауулзалтын үеэр БНХАУ-ын Сонод Зүүн хошуутай нөхөрсөг харилцаа тогтоох хамтын ажиллагааны хэлэлцээр байгуулан, Шилийн гол аймагтай “Хятад Монголын хил орчмын зам дагуух бүс нутгийн эдийн засгийн коридорыг хамтран байгуулж, уялдаатай хөгжлийг ахиулах” санаамж бичигт гарын үсэг зурлаа. 2008, 2012 оны УИХ-ын сонгуульд Дорноговь, Говьсүмбэр аймгаас хоёр удаа нэр дэвшиж ялалт байгуулж, УИХ-ын гишүүнээр сонгогдож байсан БСПУС-ын сайд Ж.Батсуурь манай аймагт зочилсон. Энэ үеэр сайд Сүмбэр сумын 2 дугаар сургууль, 5 дугаар цэцэрлэг, Усан спорт сургалтын төвөөр орж ажил байдалтай газар дээр нь очин танилцан, 2017 онд Сүмбэр сумын 2 дугаар сургуулийн 640 хүүхдийн сургуулийн шинэ барилгын ажлыг эхлүүлэхээр тавдугаар цэцэрлэгт шинээр таван хангатай иж бүрэн гэр, ЕБ-ын сургуулиудад лабораторийн тоног төхөөрөмж, цэцэрлэгүүдэд гал тогооны тоног төхөөрөмж зэрэг 91.1 сая төгрөгийн техник хэрэгслүүдийг нийлүүлсэн. Мөн аймгийн ард иргэд болон боловсрол, соёл, спортын салбарынхантай уулзалт зохион байгуулж, төр засгийн бодлого шийдвэрийг танилцуулж, иргэдийн сонирхсон асуултад хариулт өгч, санал бодлоо солилцсон. Мөн ХХААХҮ-ийн сайд П.Сэргэлэн холбогдох албан тушаалтнуудын хамт манай аймагт ажилласан. Ажлын хүрээнд Говьсүмбэр аймгийн отрын бүс нутгийн зуншлага, ногооны гарц, ургамлын бүтэцтэй танилцаж, 2016-2017 онд шилжих өвөл тус бүс нутагт гадны аймгийн малыг өвөлжүүлэхгүй байх шийдвэрийг гаргасан. Мөн Цөм сүргийн үржлийн төв ОНӨААТҮГ-ын Сүмбэр

үүлдрийн хонины удмын санг хамгаалах зорилгоор Казакстан улсаас цэвэр үүлдрийн каракуль таван хуцны үнэ 50 сая төгрөгийг 2017 оны төсөвт тусган шийдвэрлэхээ амласан. АЗДТГ-аас “Иргэдэд үйлчлэх өдөрлөг”, “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”, Авлигын эсрэг хууль тогтоомжийг сургалчлах сургалт, хэлэлцүүлгийг хамтран зохион байгууллаа. Мөн аймгийн Засаг даргын нэрэмжит “Сургалтын тэтгэлэг”-т журамд заасан болзлын дагуу хагас болон бүтэн өнчин, амьжиргааны орлого багатай, сурлагын голч дүн зэргийг харгалзан 57 оюутанд 12.5 сая төгрөгийг олгосон. Боловсрол, соёлын байгууллагуудын НДШД, халаалт, дулааны зардлын 209.9 сая төгрөгийн өрийг 2016 оны тодотголоор шийдвэрлэсэн. Энэ мэтчилэн боловсролын салбарт нэлээд анхаарал хандуулан ажиллалаа. Олон улсын ахмадын эрхийг хамгаалах өдрийн арга хэмжээг өргөн дэлгэр тэмдэглэн өнгөрүүллээ. Уг үйл ажиллагаанд УИХ-ын гишүүд Г.Мөнхцэцэг ирж ахмадуудад хүндэтгэл үзүүлсэн бөгөөд уг үйл ажиллагаанд нийт 400 гаруй ахмад настан оролцлоо. Энэ жил 16 нас хүрсэн хүүхдүүдэд иргэний үнэмлэх гардуулах “Иргэний андгай өргөх ёслол” хүндэтгэлийн арга хэмжээг аймгийн ЗДТГ, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Залуучуудын холбоотой хамтран зохион байгууллаа. Дэлхий, улсын зэрэглэлтэй тэмцээнээс медаль хүртсэн 59 тамирчин, 10 дасгалжуулагчид урамшуулал олголоо. Аймгийн усан бассейны төсөв улсын төсвөөс батлагдаж ирээгүй учраас аймгийн Биеийн тамир, спортын газрын зүгээс үйл ажиллагааг нь тасалдуулахгүйн тулд өөрийн сангаас санхүүжүүлэн, одоо таван хүний орон тоотой үйл ажиллагаагаа явуулж байна. Усан спорт сургалтын төв үйл ажиллагаагаа тасралтгүй явуулж, иргэдийг идэвхижүүлэх арга хэмжээнүүдийг тогтмол зохион байгуулан тэмцээн уралдаанд оролцож байна. Энэхүү усан спорт, сургалтын төвийг барьж, ашиглалтад оруулахад сэтгэл зүрх гарган дэмжих ажилласан Ж.Батсуурь сайдаа энэ дашрамд талархаж буйгаа илэрхийлж байна. Энэ мэтчилэн аймгийн бизнес

эрхлэгчид, газар тариалан эрхлэгчид, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид гээд аймгийнхаа хөгжилд хувь нэмэр оруулж буй хүмүүсийг ч дэмжин ажиллаж байна. Байгаль хамгааллын чиглэлд ч нэлээд анхаарал хандуулсан. Аймгийн ИТХТ-ийн тогтоолоор “Мод тарьж ургуулсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад урамшуулал олгох журам”-ын дагуу 2016 онд долоон иргэн, нэг аж ахуйн нэгж, байгууллагын тарьсан 1077 мод, бутанд байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас урамшуулал олголоо. Эдгээр иргэдээ талархал илэрхийлж, цаашид бусдыгаа уриалан улам их ногоон байгууламж бий болгохыг хүсье. Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын хувьд 2013 оноос аймгуудад ОНХС-ын бий болж, бүтээн байгуулалтын ажлуудад зарцуулагдаж эхэлсэн. Манай аймагт 2013 онд 6.5, 2014 онд 7.9, 2015 онд 4.8, 2016 онд 2.9 тэрбум төгрөг хуваарилагдаж, бүрэн зарцуулагдсан бол 2017 онд 1.1 тэрбум төгрөг тус сайд хуваарилагдаж ирээд байна. Үүнээс гадна улсын төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөрөнгө оруулалтаар олон бүтээн байгуулалт, засвар арчлалтын ажлууд хийгдсэн. Одоо цаашид Шивээ-Овоогийн нүүрсний ордыг түшиглэсэн цахилгаан станц, Дэлхийн банкны санхүүжилтээр хийгдэх Говьсүмбэр аймгийн цахилгааны шинэчлэлийн ажил, хөнгөн үйлдвэрлэлийн бүс, эрчимжсэн мал аж ахуйн бүс, дулааны станц, цэвэрлэх байгууламж, 2-р сургуулийн шинэ барилга, Сүмбэр сумын 1-р багийн бохирын шугамыг аймгийн төв цэвэрлэх байгууламжтай холбох, нийтийн эзэмшлийн орон сууцнуудын дулаалга, фасад, техникийн давхрын засвар, мал аж ахуй, газар тариалангийн чиглэл, эдийн засгийн коридор, тээвэр, соёл, спорт, амралтын хүрээлэнгийн бүтээн байгуулалт гээд хийх ажил их байна. Мөн аймгийн хот тохижилтыг сайжруулж, хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэн, хогны асуудлыг шийдвэрлэнэ. Энэ мэтчилэн та бүхэнтэй ирээдүйд хийх ажлын тухай яривал их зүйл байна. Та бидний цаг хугацаа үнэтэй. Тиймээс яриагаа энэ хүрээд өндөрлөө. Анхаарал хандуулсанд баярлалаа.

# ЦАГ ҮЕ

ТОМИЛОЛТ

# ГОВЬСҮМБЭРЧҮҮД ИРЭЭДҮЙДЭЭ ИТГЭЛТЭЙ БАЙГААГАА ИЛЭРХИЙЛЛЭЭ

—Аймгийн Засаг дарга Г.Батсуурь иргэдтэйгээ уулзаж, хийсэн ажлаа тайлагнаж, хийх ажлаа зөвшилцөв—



### Үргэлжлэл. Түүрүү нь V нүүрт

Аймгийн ЗДТГ, ИТХ хамтран өнгөрсөн хугацаанд олон ажил хийж бүтээсэн бөгөөд тэр бүхнийг тоочвол сонини нүүр ч багадахар байсан юм. Ийнхүү аймгийн Засаг дарга Г.Батсуурь илтгэл тавьж дууссаны дараа иргэд үг хэлж, асуулт асуув. Хурлыг аймгийн ЗД-ын орлогч Ш.Билэгтүвшин удирдан явууллаа. Тэрбээр “Ард иргэдээ өнөөдөр аймгийн удирдлагууд, төрийн үйлчилгээ үзүүлэх хүмүүсийг танилцуулж байгаа нь та бүхний минь ажил ямар байгууллагад, хэнд хандвал бүтэх ёстой вэ гэдгийг хэлж өгч байгаа хэрэг юм. Тиймээс ч энэ хуралд бүх шатны байгууллагуудын удирдлагууд оролцож байна. Та бүхэн сонирхсон асуултаа тавьж, шийдүүлэх асуудлууд байвал бид газар дээр нь шийдвэр гаргаж өгнө. Аймгийн Засаг даргын илтгэлд дурьдагдсанаар бид 11 дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Өнгөрсөн жилүүдэд төрийн бүх чиглэлээр дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж байсан. Энэ хөтөлбөрийг бид үргэлжлүүлэхээр шийдвэрлэсэн байгаа шүү гэдгийг хэлнэ. Сая бас Засаг даргын илтгэл дээр хөрөнгө мөнгөтэй холбоотой асуудлууд нэлээд дурьдагдлаа. Энэ

бүхнийг нээлттэй, ил тод хэлж байгаагийн учир нь бид иргэддээ нээлттэй байх. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж гэж шийдсэнтэй холбоотой. Бид 2017 онд 1.1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийнэ. Урьд нь ямар хэмжээтэй байсан талаар та бүгдэд сая харууллаа. Гэхдээ бид хөрөнгө мөнгө бага байна гээд зүгээр суухгүй. Гадаадын төсөл хөтөлбөрийг орон нутаг руугаа татах, бүтээн байгуулалтыг өрнүүлэх, Засгийн газрын шийдвэрт тусгагдсан бүтээн байгуулалтын чиглэлээрх ажлуудыг Говьсүмбэр аймагтаа хэрэгжүүлэхийг зорьж байгаа. Говьсүмбэр аймгийн Засаг дарга жилд багадаа хоёр удаа иргэдтэйгээ уулзаж байж гэж шийдсэн. Ингээд нутгийн зон олон та бүхэн сонирхсон асуултаа тавиаарай. Бид бүгд, ялангуяа аймгийн Засаг дарга түүний Тамгын газар, хэлтэс, агентлагийн дарга нар энэ байгаа учраас харуулахад бэлэн байна” хэмээв. Ийнхүү иргэдийн санал шүүмжлэл, асуулт хариултаар уулзалт үргэлжиллээ. Хамгийн туруунд Говьсүмбэр аймгийн хөгжлийн төлөв төрийн захиргааны байгууллагад удирдах албан тушаал хашиж байсан, эдүгээ өндөр настны тэтгэвэртээ суугаад байгаа Д.Амарсайхан гуай захиас сургаалиа хайрласан юм.

ажиллана.  
**Д.Гантөмөр:** Одоо ард иргэд их тайван, сэтгэл хангалуун байна

/ҮГХ-ны дарга/

- Аймгийн удирдлагууд ажлаа аваад багагүй хугацаа өнгөрч байгаа ч чамгүй олон ажлыг хийсэн гэж бодож байна. МАН гарснаар маш аявдуухан байгаа. Одоо ард иргэдийн сэтгэл санаа их тайван, сэтгэл хангалуун байна. Хуучин бол бие биеэ мууддаг, хов жин ярьдаг байсан. Одоо тийм байгаа болсон. Ингээд би хэдэн санал хэлье. Юуны түрүүнд зарим дэлгүүрүүдийн ажлыг цагийг богиносгомоор байна. Дэндүү орой болтоод ажиглах, архи зарж байна. Хоёрдугаарт, Сум хөгжүүлэх сан гэж бий. Энэ сангаас хэдхэн хүн зээл авчихаад, зээлээ төлж барагдуулаагүй байна. Дараачийн хүмүүс нь зээл авах боломжгүй болоод байна. Гуравдугаарт, манай аймагт мэдээ мэдээлэл гэж үнэхээр алга байна. Байгууллагууд юм хийгээд байдаг бид мэдээгүй л байдаг. Үүнд бас анхаарч ажиглах хэрэгтэй. Мөн хүүхэд хамгаалах байр. Миний ганд ярьдаг зүйл. Энэ асуудлыг хэдэн жил ярьж байгаад П байранд нэг байртай болгосон. Энэ байранд орох хүүхэд олон байна. Түүний хажуугаар зовлонгоо тоочоод ирж байгаа өндөр настнууд байна. Тэгэхээр энэ байранд хөгжлийн бэрхшээлтэй, өндөр настнуудыг байрлуулж болох болов уу. Засаг даргын хөтөлбөрт нийгэмд чиглэгдсэн, нэлээд үг дүнтэй ажлууд төлөвлөгдсөн байна. Үүнийг цаг хугацаанд нь хийвэл сайн байна. ТББ-уудтай нягт хамтарч ажиллаарай байна. Ард иргэдийнхээ хяналтыг бий болгомоор байна. ИТХ-ын төлөөлөгчид маань ойл өрхүүдээр явж ажилласан байна билээ. Энэ мэтчилэн маш сайн тулж ажиллаарай гэдгийг хэлмээр байна.

**Ж.Чадраалбал:** Одооноос л анхаарахгүй бол утааны асуудал нэлээд их болох нь

/Ш багийн иргэн/

-Засаг даргын таван сарын хугацаанд хийсэн ажлыг танилцуулж байна. Нэлээд ажил хийсэн нь хүн болгонд ойлгомжтой байна. Миний хувьд энэ утааны асуудал үнэхээр хэцүү байна. Одоо энэ нэгдүгээр арван жилийн цаад талын дугуй дэлгүүрээс Наран кафе хүртэл утаатай байна. Энэ хавиар манаач, сахил айлууд байдаг юм уу, өглөө болохоор нил утаа байдаг. Цаад талын 10, 11, 12 дугаар байрны оршин суугчид цоох онгойлгох арга байдаггүй. Хоёр талаас нь утаа саагчихдаг юм байна билээ. Наанаас нь ч утаа, цаанаас нь ч утаа. Одооноос л анхаарахгүй бол утааны асуудал нэлээд их болох гэж байна. Энэ чинь уурын зуухнаасаа холболт авахад уг нь ойрхон газар шүү дээ. Албан газруудаасаа холболт аваад халаалтыг нь тавьж болдоггүй юм уу. Заавал энэ жижиг уурын зуух байх шаардлага байна уу, үгүй юу гэдгээт анхаарах хэрэгтэй. Хоёрдугаарт, энэ урд талын газар колонк бий шүү дээ. Тэр хавиар бүр мал бэлчиж байгаа юм шиг л гялгар уут хийсээд байх юм. Түүнийг даруйхан цэвэрлэхгүй бол болохгүй байна. Ямар ч байсан цэвэрлэхгүй бол дэндүү болсон. Гуравдугаарт, 10, 11 дүгээр байрны гадна талын фасадын ажлыг хийнэ гэж дөрвөн жил ярьсан. Энд эрэмбэлнэ гээд байдаг. Гэтэл тэр сууцанд амьдарч байгаа 20-нодхон айл байдаг. Санал өгдөг юм байдаггүй. Ингээд хаягддаг. Сая Хонхорын байруудыг ярьж байна билээ. Энэ байрнуудын засварын ажлыг хийж өгөх үү, үгүй юу гэдгийг асуух гэсэн юм. Мөн энэ хавь чинь манай төвийн хэсэг. Энэ дагуух хамааг цэгцэлж хотынхоо өнгө үзэмжийг сайжруулаарай байна.

**Д.Амарсайхан:** Байгаа орчин нь амар амгалан байхад л ард түмний чинь итгэл сэргээд ирдэг юм

/Ш багийн иргэн/

-Миний хувьд асуух зүйл алга. Засаг даргын тайланг сонслоо. Та бүхнийг сэтгэл, зүтгэл гарган чармайж ажиллаж байгаа гэдгийг олон түмэн ойлгож байх шиг байна. Ингээд та бүхэнд ажлын амжилт хүсээд таван зүйлийн захиас хэлье гэж бодож байна. Нэгдүгээрт, өмнө нь хийж, эхлүүлсэн ажлуудыг үргэлжлүүлж үзээрэй. Бидэнд нэг муухай дутагдал байдаг. Өмнө нь байсан хүн юу ч хийгээгүй юм шиг өөрсдөө л юм хийж гэж байгаа юм шиг хандвал олон түмэн хүлээж авдаггүй юм шүү. Тиймээс урьд нь хийсэн сайн, муу ажлуудаа шигшиж байгаад үргэлжлүүлээрэй. Мөн Чойр анх байгуулахдаа усны хайгуулыг хийгээд, нөөцөө тогтоосон. Гэтэл яг тэр эх үүсвэр дээр суурьшлын бүс хийж байгаа юм шиг байна билээ. Тэгж болохгүй шүү. Түүнчлэн цэвэрлэх байгууламжийн асуудлыг ярьж байна. 1992 онд нийтийн аж ахуйн үйлчилгээний барилга дээр ажиллаж байсан пүүсүүдийг тарахад “Од” гэдэг пүүсийг авч ирж байгаад зургийн нь хийлгэсэн байсан. Түүнийг та нар үргэлжлүүлээрэй. Тэр та нарын хийж гэж байгаа ажилд их хэрэг болох юм шүү. Ер нь болж өгвөл та нар минь битгий улстөржөөрэй. Говьсүмбэр аймаг хэзээ ч улстөржиж байгаагүй. Хамгийн ичгэвтэр юм өнгөрсөн хавар болж байсныг энд сууж байгаа бүх хүн мэдэж байгаа. Хэдийнхээ байх тал талд гараад бие биеэ муулаад байж болохгүй. Ажилд чөдөр тусгаа болдог зүйл чинь энэ шүү. Та бүхний авууштай нэг зүйл нь хүмүүсийг халж, сольсонгүй. Их аялдуу зөөлөн яваа чинь энэ байна. Харахад байрлаамаар сайхан залуучууд байгаа учраас эв нэгдэл их чухал гэдгийг дахин дахин хэлмээр байна. Гуравдугаарт, эдийн засаг хүнд байгаа. Тэр гачаал та нар дээр ирж байна. Одоо төсөв багасчихлаа. Багасаад багасаад 1.1 тэрбум. Ямар хэцүү үед энэ аймгийг байгуулж байсныг та нар эргээд сана даа. Жилийн төсөв 360 сая төгрөг байсан. Тийм нөхцөлд байгуулаад, суурийг нь тавьчихсан юм чинь одоо зөв аваад явахад та нар мөнгө дутагдана гэж байхгүй. Сэтгэл л хэрэгтэй. Мөнгөгүйгээр хийгээд олон ажил байдаг юм шүү. Харууцлага, сахилга бат, сэтгэл байдаг юм. Ийм зүйлд л анхаарч ажиллаарай гэж залуучуудад би захиж хэлэх гэсэн юм. Ер нь бол бодлогоо л их эв гаргах ёстой юм. Ямагт хяналт их чухал байдаг юм. Түүнийг л та нар аль ч төвшиндөө хангаж ажиллаарай. Мөн нэг зүйлийг захиж хэлэхэд ерөөсөө байгалийн хүн л бүтээдэг юм билээ. Тэгэхээр та бүхэн үлгэр жишээ, ногоон хот байгуулч хэрэгтэй. Байгаа орчин нь амар амгалан, тайван байхад л ард түмний чинь итгэл сэргээд ирдэг юм. Тийм учраас сайхан, эв найртай, гадаа гарахад сэтгэл дүүрэн байх

тийм л хотыг бий болгочих. Нэг хүний ч гэсэн идэвх зүтгэлийг үнэлж байгаарай. Харах нүдтэй л байж үзээрэй. Та нөхдөд амжилт хүсье.

**Д.Гарамдорж:** Хүүхдүүддээ үлгэр жишээ болоод өгөөч, ХҮМҮҮС ЭЭ

/Төлөр замын I багийн иргэн/

-Цэвэр ариун байдлын төлөө ганц хоёрүг хэлье. Хүүхэд, томчууд бид бүгд л уусан ундааныхаа сав, тамхичид бол хаа таарсан газраа тамхины ншээ хаяж байна. Тэгэхээр хогийн савыг их болгох хэрэгтэй байгаа юм. Сүүлийн үед сайжирч байгаа л даа. Зам талбайгаа сайхан цэвэрлэж байна. Гэхдээ хогийн сав л дутагдалтай санагдаад байгаа юм. Ялангуяа төмөр замын орчимд гурван хогийн сав байдаг. Тэнд нь иргэд хогийн хийгээд бүр дүүргэчихдэг. Ийм байж болохгүй ээ. Гадаад, дотоод руу их л явж байна. Соёлтой орнуудын юм их үзэж байгаа харагдаж юм. Яагаад сураццатгүй юм бэ. Үүнд нэг анхаараад хүүхдүүддээ үлгэр жишээ болоод өгөөч, хүмүүс ээ.

**Ч.Алтанболд:** Нутаг орноо мэддэг хүмүүс ирсэн тул манай нутгийн ирээдүй өнгөтэй, гэрэлтэй харагдаж байна

/Байгаль орчны иргэний зөвлөлийн тэргүүн/

-Та бүхний энэ өдрийн амгаланг эрье. Өнөөдөр 2016 он улирч, 2017 оны босгон дээр шинэ удирдлагууд хийсэн ажил, цаашид хийх ажлынхаа талаар ярьж байгаа нь цаг үеэ олсон асуудал байна. Тийм учраас үүнтэй холбогдуулаад нэг асуулт тавья. Чойрын богд уульг улсын тусгай хамгаалалтад авсан. Сая орон нутгийн тусгай хамгаалалтад үргэлжлүүлээд авлаа. Энэ нутаг дэвсгэр дээр байгаа зуслангийн байшин, зарим хуучин фермийн барилгуудыг хувь хүмүүс очоод нураагаад, буулгаад авчихсан байгаа. Тусгай хамгаалалттай газар нутаг дээр байгаа хувь хүний өмч чинь тэртэй тэргүй улсын өмч шүү дээ. Энэ өмчүүдийг тусгай хамгаалалтын зэрэг нутагсаа ямар зохицуулалтаар авах вэ гэдэг асуудал дээр шийдвэр гаргах хэрэгтэй байна. Хоёрдугаарт, хөгжингүй улс орон яаж хөгжсөн байна вэ гэхээр хогныхоо асуудлыг үе шаттайгаар, зөв зохиистой хийснэйтэй холбоотой. Манайх ч гэсэн хоггүй аймаг болох, эрүүл чийрэг, эко орчин бүрдүүлэх боломж байгаа. Миний хувьд Говьсүмбэр аймгийн Монголын байртай орчны иргэний зөвлөлийг тэргүүлж байгаагийн хувьд байгаль орчны төлөө ажилладаг ТББ-ууд орон нутгаа хог хаягдалгүй байлгахын төлөө хамтран ажиллахад бэлэн байгаагаа илэрхийлж байна.

**Ш.Билэгтүвшин:** Та бүгдийн санаа бодлыг сонсож, тулж ажиллана

/Аймгийн ЗД-ын орлогч/

-Ч.Алтанболд гуайд баярлалаа. Хоёр асуулт асууж байгаа юм байна. Чойрын богдын тусгай хамгаалалтын газарт байгаа зуслангийн байрны мэдээлд аваач гэж байна. Энэ бол яалт ч үгүй тухайн үедээ хувийн эзэмшилд очсон барилга байгууламж байгаа. Энэ чиглэлээр бид судлаад танд харуу мэдээлнэ. Мөн хийсэн ажлаа мэдээлдэг байх хэрэгтэй гэж байна. Бид өнөөдрийн байдлаар ажлаа аваад таван сарын дараа мэдээллээ хийж байна. Цаашид иргэдтэйгээ их ойр, байнга мэдээлэл хийж, та бүгдийн санаа бодлыг сонсож, тулж

**Н.Дэрэм:** Усан санг цэвэршүүлж болдоггүй юм уу

/I багийн иргэн/

-Төлөвлөлт дээр нэгдүгээр багийн цэвэр усны асуудал гарахгүй байна. Өөрөөр хэлбэл, төмөр замын таван давхар, нэг болон хоёрдугаар давхруудад цэвэр ус маш бохир. Бид хаанаас цэвэр усаа авч байна вэ гэвэл машинаасаа ус аваад уух, хоол хийх жорлонг солиод ч нэмэргүй. Сайндаа зургаан сар болоод л ув улаан болдог. Крантнаасаа ус аваад уух, хоол хийх асуудал ерөөсөө байхгүй. Усанд орсон ч цэвэр усанд орж чадаагүй. Тэгэхээр таны төлөвлөгөөнд цэвэр усны талаар огт тусгагдсангүй. Нэгдүгээр багийн нутаг дээр цэвэр усны сан гэж байна уу. Энэ усан санг цэвэршүүлж болдоггүй юм уу. Энэ дөрвөн жилд та бүхэн энэ ажлыг хийх үү. Олон даргын нүүр үзсэн ч огт хийгддэггүй нэг ажил байгаад байна. Шийдэж өгөөч ээ.

**Ю.Цэндмаа:** Оюун санааны өөрчлөлт хийх цаг нь болжээ

/I багийн иргэн/

-Аймгийн удирдлагуудад талархал илэрхийлнэ. Учир нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн олон улсын өдрийг аймгийн удирдлагууд маш сайн зохион байгуулж, бүтгээрээ ирж гүнээ хүндэтгэл үзүүлсэнд талархаж байна. Үүнээс гадна нэг санал байна. Засаг дарга сая СОХ-ны мөнгөө хүмүүс өгөхгүй байна гэлээ. Ж.Цадраабал гуай ч ярьлаа. Хог хаяад хийсэн гэж. Эндээс дүгнэлт хийгээд харахад хүмүүсийнхээ оюун санаа, ухамсрыг дээшлүүлэх нь энэ цагийн чухал асуудал болчихоод байгааг харуулж байна. Өнөөдөр аймгийн удирдлагууд маш их хөрөнгө оруулалт гэдэг материаллаг тал руугаа их хөрөнгө оруулалт хийсэн байна. Одоо харин хүмүүсийнхээ оюун санаанд анхаарч, оюун санааны өөрчлөлт хийх цаг нь болжээ. Тиймээс оюун санааны хөрөнгө оруулалт хийх зорилго тавинаас гэж та бүхнээсээ хүсч байна.

**Н.Энхбаяр:** Эрчимтэй ажиллаарай гэж хүсч байна

/Ш багийн иргэн/

-Өнөөдөр та бүхэн намчир хахгүйгээр ажлаа зохион байгуулах хэрэгтэй. Мөн хогноос эхлээд нийгмийн асуудлуудыг шийдэх шаардлагатай байна. Ард иргэддээ ойр дотно ажиллах хэрэгтэй, түүнээс биш дарга болгон гээд томроод байх асуудалгүй. Аймаг, сум, баг нь ч адилхан. Яг үнэндээ нэг нэгэндээ найр тавиад байна шүү. Багийн дарга нар сайн ажиллаж байгаа гэж сумын дарга нар бодоод байдаг. Сумын дарга нар гайгүй байх аа гээд аймгийн дарга нар бодоод байдаг. Энэ мэтчилэн найр тавьж, найрсаг байна, сайн байна гэж дүгнэж байна. Тэр тийм биш шүү. Найрсаг байна, амгалан тайван байна гэж ерөөсөө хэлж болохгүй. Нөгөө талаар сэхээтнүүд та нар, иргэдийн хурлын төлөөлөгч та нар маш түргэн шуурхай ажиллаж байх ёстой юм шүү. Дээр дээрээсээ хяналттай болгох хэрэгтэй. Аймгийн Засаг даргын Тамгын газар бий болоод таван сар болж байгаа ч алгуурхан байна. Эрчимтэй ажиллаарай гэж хүсч байна.

**Ж.Раднаа:** Бид та нарт итгээд сонгосон, та нар бидний итгэлийг дааж явж чадах байх

/I багийн өндөр настан/

-Би энэ ширээний урд суусан таван хүнтэй юм ярихгүй. Бид та нарт итгээд сонгосон. Та нар бидний итгэлийг дааж явж чадах байх. Харин та нарын ард сууж байгаа дарга нар, энд сууж байгаа дарга нар хандаж үг хэлмээр байна. Ямар нэгэн бичиг цаас бариад очихоор энд сууж байгаа дарга нар биднийг мадаах байх юм. Би ямар хов зөөгөөд Г.Батсуурь

дарга дээр гүйгээд оролтой биш. Шат шатаа дагамаар байгаа юм. Үнэндээ энэ газрын дарга нарын доор ажиллаж байгаа хүмүүс ард түмэн бидэнд их хатуу хандаж, асуудлыг шийдэж өгөхгүй гацаадаг. Юм болгоныг дарга нар дээр бариад орох хэцүү. Тийм болохоор доороо ажиллаж байгаа хүмүүстээ хяналт тавьж, шаардмаар байх юм.

Энэ мэтчилэн иргэд асуулт асууж, зарим нь чин сэтгэлийн үгээ хэлсэн юм. Энэ үеэр газар, албаны дарга нар иргэдээс ирсэн асуултад хариулт өгөв. Тодруулбал, “Хүүхдийн мөнгөө авч байгаад больчихлоо, яаж авах вэ”, “Өрхийн судалгаа авахдаа ар тал, ах дүү хармааргүй баймаар байна. Тусдаа гарсан өрхийг тусад нь авч үзэж, тусалж дэмжээч”, “Халаалтын тал дээр анхаарал тавьмаар байна, халаалт муу байна” гэх зэрэг нийгмийн шинж чанартай олон асуулт иргэдээс бичгээр ирсэн юм. Тэр бүхэнд хариуцсан дарга нар нь хариулт өгч, зарим асуудлыг газар нь шийдвэрлэхийг аймгийн ЗД-ын орлогч Ш.Билэгтүвшин үүрэгдэв. Энэ дагуу Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын дарга Д.Гансүх, Сүмбэр сумын Засаг дарга Т.Амарсайхан, “Ус-Лу” ОНӨУ-ын дарга Ганзориг, “Тохийжилт сүмбэр” ОНӨААТҮГ-ын дарга Энхбаатар, Авто тээврийн төвийн тээвэр зохицуулагч Э.Урачимзэг нар иргэдийн асуултад хариулт өгсөн юм. Мөн аймгийн ЗД-ын орлогч Ш.Билэгтүвшин зарим асуултад хариуцсан. Тэрбээр “Аймгийн Засаг даргын орлогчийн хувьд, тодорхой зөвлөлт, комиссыг ахиадгийн хувьд хэд хэдэн асуултад хариулт өгнэ. Сургалтын тэтгэлэгтэй холбоотой, ялангуяа сургалтын төлбөрийг холбоотой асуултууд байна. Бүтэн өнчин, хагас өнчин оюутнуудыг тэтгэлэгт ажилхан хамруулаач, тус тусад нь харж үзээч гэсэн байна. Тэтгэмжид хамруулахдаа адилхан 250 мянган төгрөг өгсөн байсан. Үүнийг иргэд эмзэгээр хүлээн авсан гэж байна. Энэ бол эмзэгээр хүлээж авах хэрэг биш. Бид бүхэн аймгийн Засаг даргын боловсролыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд сурч байгаа иргэдэд буцаалтгүй мөнгөн тусламж л өгч байгаа юм. Энэ хүрээнд ажил авснаас хойш наймдугаар сард 50 орчим оюутанд сургалтын тэтгэмж өгсөн. Энэ бол ард иргэдэд хэрэгтэйгэй зүйл болсон байх гэж найдаж байна. Цаашид үнэхээр иргэд болсон. Боловсролыг дэмжих хөтөлбөрт өнгөрсөн дөрвөн жилд 80 гаруй сая төгрөг тавьж байсан бол одоо 10 сая төгрөг л тавьж байгаа. Үүнийг юунд зарцуулах вэ гэдэг багш нараа чадавхижуулахад зарцуулаа. Учир нь багш нараа чадавхижуулаач, урсгалаараа яваад байгаа юм биш үү гэсэн санал их ирдэг. Тэгэхээр энэ чиглэл рүү нэлээд хөрөнгө тавина. Одоогоор оюутнуудад тэтгэмж, тусламж өгөх асуудал дээр боломжгүй байгаа шүү гэдгийг хэлэх нь зүйтэй байх. Дараагийн асуудал, архи зардаг дэлгүүрийн цагийг өөрчлөөч гэж байна. Хуулиараа 00:00 цаг гэж заасан байгаа. Монгол Улсын хууль тогтоомжийг Монгол Улсын газар нутаг дээрх бүх аймаг дагаж, мөрдөх ёстой. Тиймээс яг тэд болгоно гэсэн боломж одоогоор байхгүй байна. Цаашид асуудлыг судалж, шийдвэрлэе. Хоёрдугаар сургуулийн ойролцоо замын тэмдэг, тэмдэглэгээ хийх хэрэгтэй байна гэсэн байна. Энэ бол бас зөв зүйтэй асуудал. Ялангуяа бид Хонхорын байруудын голд, нэгдүгээр сургуулийн зам дээр хурд сааруулагчийг тавьсан. Энэ бол хүүхдүүдийн амь нас, эрүүл мэндтэй асар их холбоотой зүйлс. Мөн ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ч хамаатай. Цаашид Автозамын сангийн хөрөнгөөр хурд сааруулагч, тэмдэг тэмдэглэгээг тавина. 2017 оны төсөв дээр нэгдүгээр багт гэрэлтүүлэг нэмж тавихаар төсөв шийдэгдсэн байгаа. Тодорхой хэмжээний төсөв шийдвэрлэсэн байгаа шүү гэдгийг дахин хэлнэ. Ажлын гараагаа зөв эхэлж, аймгийн хөгжил дэвшилд хувь нэмрээ оруулж ажиллаарай, ажлын амжилт хүсье гэсэн байна. За байрлалаа та бүгдэд. Хэцүүдээ бэрхшээлийг давж явна шүү. Ингээд иргэд та бүхэн бидний зохион байгуулсан уулзалтад хүрэлцэн ирсэнд баярлалаа. Бид бүхэнд үнэтэй санаа, зөвлөмж өгнэ. Тэр бүхнийг ажилдаа хэрэгжүүлж ажиллана. Гол нь хөрөнгө мөнгөндөө биш. Битгий улстөржиж, намчирхаарай, ажлаа хийж чадаж байгааг нь ажиллуулаарай гэж байна. Та бүхний хэлж буй захиас, эвтэй, зүтгэлтэй бай гэж хэлж байгаа угсийн тань бид хүлээж авна. Говьсүмбэр аймгийнхаа хөгжлийн төлөө хамтдаа зүтгэж гэж та бүхнээс уриалмаар байна” хэмээснээр энэ удаагийн уулзалт өндөрлөлөө.

ЦАГ ҮЕ

# Говьсүмбэрийг ХӨГЖҮҮЛЭХ, ХИЙХ АЖИЛ ИХ БАЙНА

**Хэрэгжүүлэхээр батлуулсан бодлогын баримт бичгүүд**

- Аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр
- Аймгийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл
- Аймгийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох журам
- Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор 11 дэд хөтөлбөрийг Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн тэргүүлэгчдийн хурлаар батлуулсан.

**Дэд хөтөлбөрүүд**

- Төрийн албан хаагчдын харилцаа, хандлага, ёс зүйг сайжруулах аймгийн дэд хөтөлбөр
- Хууль зүйн байгууллагуудын үйлчилгээний чанарыг сайжруулж, иргэдэд эрх зүйн мэдлэг олгох аймгийн дэд хөтөлбөр
- Аялал жуулчлалыг хөгжүүлэх аймгийн дэд хөтөлбөр
- Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх аймгийн дэд хөтөлбөр
- Боловсролыг дэмжих аймгийн дэд хөтөлбөр
- Эрүүл мэндийн салбарыг хөгжүүлэх аймгийн дэд хөтөлбөр
- Биеийн тамир, спортыг хөгжүүлэх аймгийн дэд хөтөлбөр
- Соёл, урлагийг хөгжүүлэх аймгийн дэд хөтөлбөр
- Зорилтот бүлэгт чиглэсэн аймгийн дэд хөтөлбөр
- Иргэдийн экологийн боловсролыг дээшлүүлэх дэд хөтөлбөр
- Аймгийн гадаад харилцааг салбараар хөгжүүлэх хөтөлбөр

**Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт**

Говьсүмбэр аймгийн хөгжлийн сангийн 2013-2015 оны хөрөнгө оруулалт /сая.төг/

Хөрөнгө оруулалт		2013 он	2014 он	2015 он	2016 он	Нийт
Орон нутгийн хөгжлийн сан	Хуваарилагдсан	5940.3	7328.7	3308.7	2227.4	18805.1
	Санхүүжсэн	5438.1	5424.9	2721.1	2111.0	15695.1
Нийт хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын тоо		83	138	142	78	441

2017 онд 1185.3 сая төгрөг хуваарилагдсан.

**Цаашид хийгдэх ажлууд**


Хятад, Монгол хоёр улсын төрийн тэргүүний хэлэлцээ хийгдсэн. Анхны төслөөр 9200 мВт-ын хүчин чадалтай цахилгаан станц баригдах бөгөөд энэ төсөл хэрэгжсэнээр 3000 орчим байнгын ажлын байр бий болно. Энэ бүтээн байгуулалтыг хийхэд дөрвөн жил хүрэлцэхгүй байхыг үгүйсгэхгүй ч их итгэл найдвар тавьж байна.



Дэлхийн банкны санхүүжилтэйгээр Монгол Улсад эрчим хүчний төсөл хэрэгжихээр болсон. Энэ төслийн хүрээнд Говьсүмбэр аймагт 25 км 0.4-ийн шугам, 17 км 0.6-ийн шугам, цахилгааны эх үүсвэр 4, айл өрх болоод аж ахуйн нэгжүүдийн тоолуурыг бүрэн солих асуудал яригдаж байна. Энэ төсөл хэрэгжсэнээр манай аймаг цахилгааны асуудлуудаа бүрэн шийдвэрлэнэ.



Хөнгөн үйлдвэрлэлийн бүс, эрчимжсэн мал аж ахуйн бүсийн хөгжүүлэх асуудлыг чухалчлан тавьж байна. Эдгээр бүсүүдийн дэд бүтцийн асуудлыг шат дараатайгаар хийж дуусгахаар төлөвлөж байна.



Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд ямар нэгэн тэмдэглэлт ой, арга хэмжээ зохион байгуулах, санхүүгийн тусламж дэмжлэг биш нэгдэж, нийлж бүтээн байгуулах, төр нь баялаг бүтээгчдээ, иргэдээ дэмжсэн бодлогыг боловсруулахаар ажиллаж байна.



Дулааны станц, цэвэрлэх байгууламжийн асуудлыг шийдвэрлэхийн төлөө ажиллах болно. Энэ дөрвөн жилд хийгдэхэд маш хэцүү боловч бид хөгжил, дэвшлийн тухай ярьж, зорьж байгаагийн хувьд энэ асуудлыг шийдвэрлэхийн төлөө ажиллана.




Аймгийн хот тохижилтыг сайжруулж, хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэн, хогны асуудлыг шийдвэрлэнэ.



640 хүүхдийн 2 дугаар сургуулийн шинэ барилгын асуудлыг ирэх онд шийдвэрлэхээр болсон. Ирэх дөрвөн жилд үе шаттайгаар сургууль, эцэрлэгүүдийн гадна тохижилт, дотор засварын ажлыг хийнэ.



Сүмбэр сумын 1-р багийн бохирын шугамыг аймгийн төв цэвэрлэх байгууламжтай холбох талаар төмөр замын удирдагуудаа санал хүсэлтээ илэрхийлсэн. Хоёр талаас ажлын хэсэг байгуулж, энэ ажлыг ирэх жил амжуулж хийхээр ярилцаж байна.



Нийтийн эзэмшлийн орон сууцнуудын дулаалга, фасад, техникийн давхрын засварыг үе шаттайгаар хийж дуусгахаар төлөвлөж байна. Гадна талын фасадыг засварлахаас илүүтэйгээр техникийн давхар буюу подвалуудын шугам хоолой, лаг зөөх, засварын ажил их чухал байна. Тиймээс энэ асуудалд бид богино хугацаанд анхаарч ажиллана.



Мал аж ахуй, газар тариалангийн чиглэлд анхаарч ажиллана. Малын чанар, үүлдэр, угсааг сайжруулах, эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэхэд бодлогоор анхаарч ажиллана. Газар тариалангийн хувьд аймгийн хүн амын хэрэгцээг хангах хувь хэмжээг өмнөх жилүүдээс бууруулахгүйгээр техник тоног төхөөрөмжийг авч ашиглахаар төлөвлөсөн.



Монгол, Орос, Хятад гурван улсын Эдийн засгийн коридорын анхны туршилтын ачаа тээврийн цуваа манай аймгаар дайрч гарсан. Говьсүмбэр аймгийн хувьд Орос, Хятадыг холбосон босоо тэхлэгийн авто замын голд байрлалтайгаараа ирээдүйд ачаа тээврийн болоод аялал жуулчлалын хувьд ихээхэн ач холбогдолтой. Бид энэ давуу талаа зөв ашиглах хэрэгтэй. Энэ асуудлыг хувийн хэвшилтэй хамтарч шийдвэрлэгдэнэ гэдэгт итгэж байна.



Соёл, спорт, амралтын хүрээлэнгийн бүтээн байгуулалтыг үргэлжлүүлэн хийнэ. Аймгийн соёл, спорт, амралтын хүрээлэн говьсүмбэрчүүдийн хувьд чөлөөт цагаа өнгөрөөдөг чухал газар болсон.



АМЖИЛТЫН ЭЗЭД

# Шингэйн шингэ тамирчнаар Д.СУМЬЯА, Д.ОТГОНДАЛАЙ нар тодорлоо

Н.ПУНЦАГБОЛД

МҮОХ-ны тэргүүн дээд шагнал гардуулах “Бөртэ чоно-2016” ёслолын ажиллагаа өнгөрсөн долоо хоногийн баасан гарагт болж, энэ оны шилдэг тамирчид тодорсон юм. Монгол Улсын шилдэг тамирчныг тодруулах 15 дахь удаагийн ёслолын ажиллагаанд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Ц.Баярсайхан, БСШУС-ын сайд Ж.Батсуурь, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвлөх, МХБХ-ны ерөнхийлөгч А.Ганбаатар, Батлан хамгаалахын сайд, УИХ-ын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Биеийн тамир спортын газрын дарга Ц.Шаравжамц нарын албаны хүмүүс урилгаар оролцсон юм. Түүнээс гадна Олимпын алт, мөнгөн медальт Н.Түвшинбаяр, олимпын мөнгөн медальт П.Сэрдамба, Д.Сумьяа, олимпын хүрэл медальт С.Батцэцэг, Д.Отгондалай, паралимпын хүрэл медальт Б.Ууганхүү, Э.Содномпилжээ нарын шилдэг тамирчид оролцлоо.

“Бөртэ чоно-2016” ёслолыг нээж, МҮОХ-ны ерөнхийлөгч Д.Загдсүрэн үг хэлэв. Тэрбээр “Эрхэм хүндэт зочид төлөөлөгч спортын зүтгэлтнүүд та бүхэнд мэнд хүргэе. Өвлийн жавартай үдэш энэ халуун танхимд та бүхэнтэйгээ спортын шилдгүүдээ шалгаруулахаар цуглаад байна. “Бөртэ чоно” наадам 15 дахь жилдээ амжилттай зохион байгуулагдаж байгааг хэлэхэд таатай байна. Өвлийн олимпын анхны медаль хүртсэн, зуны олимпын наадмаас мөнгө, хүрэл медаль хүртэж медалийн сангаа арвижуулсан зэрэг сайхан амжилтаар бид 2016 оныг үдэж байна” хэмээн



Гэрэл зургийг Г.АРТУУЖИН



хэлсэн юм. Түүний дараагаас шилдэг тамирчдыг тодруулах үйл ажиллагаа эхэлж, 2016 оны шилдгийн шилдэг эмэгтэй тамирчнаар Рио-2016 Олимпын наадмын мөнгөн медальт Д.Сумьяа тодорсон. Харин шилдгийн шилдэг эрэгтэй тамирчнаар Рио-2016 Олимпын наадмын хүрэл медальт Б.Отгондалай тодорсон юм. Ерөөсөө 2016 онд болсон хамгийн онцлох наадам нь олимп. Рио-2016 Олимпын наадамд манай улс түүхэнд байгаагүй олон тамирчин оролцуулсан. Тэр дундаа чөлөөт, жүдогийнхон бараг л бүтэн багараа оролцсон юм. Гэвч ердөө хоёрхон хүн медаль авсан. Жүдогийнхон дунд маш олон хүн Олимпын найдвар болоод байсан. 2-3 хүн медаль авах боломжтой байсан.

Гэвч 57 кг-ын жинд өрсөлдсөн Д.Сумьяа мөнгөн медаль хүртэж, жүдогийнхний нэр төрийг аварсан. Дэлхийн аварга М.Уранцэцэгийн хувьд хагас шигшээд Солонгосын бөхөд харамсалтай ялагдаагүй байсан бол аварга болох байсан. Гэвч хагас шигшээд ялагдаж, хүрэл медалийн төлөө Японы Конда Амид ялагдаад дууссан юм. Гэхдээ тэрбээр Токиод түрүүлж, өөрийгөө ямархуу энгэй бөх болохоо харуулсан. Энэ жил шилдэг эмэгтэй тамирчны төлөө

энэ хоёр бөх л өрсөлдөх боломжтой байсан. Харин Д.Сумьяа яах аргагүй Олимпын мөнгөн медаль хүртсэн амжилтаараа шилдэг боллоо.

Эрэгтэй тамирчдаас бол ганц торойж байгаа нь Д.Отгондалай. Түүнээс өөр өндөр амжилт үзүүлсэн тамирчин байхгүй. Харин Г.Мандахнаран хүрэл медаль хүртэж чадсан бол өрсөлдөөн энэ хоёрын хооронд өрнөх байлаа. Шилдэг дасгалжуулагчаар мэдээж Х.Эрдэнэт-Од, Д.Сумьяаг Дэлхийн мастеруудын тэмцээнд гурав түрүүлэх, дэлхийн аваргаас хүрэл медаль авах, Олимпын наадамд финалдахихамжилтын замыг зассан хүн нь Х.Эрдэнэт-Од дасгалжуулагч. Тиймдээ ч энэ жил шилдгээр шалгарлаа. Харин шилдэг спортын холбоогоор Монголын Жүдо бөхийн холбоо тодорсон. Энэ жил Монголын жүдочид авсан медалийнхаа тоогоор дэлхийд тавдугаарт эрэмбэлэгдсэн. Олимпын наадамд бүрэн бүрэлдэхүүнээрээ шахам орсон. +78 кг-ыг эс тооцвол. Нэг мөнгөн медаль, хоёр тавдугаар байртай ирсэн. Энэ хэмжээний амжилт үзүүлсэн холбоо манайд байхгүй. Тиймдээ ч Жүдо бөхийн холбооны Ерөнхийлөгч Х.Баттулга ч гэсэн шилдгээр тодорсон юм.

“Бөртэ чоно” наадмын шилдгүүдийг танилцуулъя.

## ОНЫ ШИЛДГИЙН ШИЛДЭГ ЭРЭГТЭЙ ТАМИРЧИН:

Д.ОТГОНДАЛАЙ /бокс/ “Рио-2016” олимпын наадмын хүрэл медальт, Олимпын эрхийн тэмцээний аварга.

## ОНЫ ШИЛДГИЙН ШИЛДЭГ ЭМЭГТЭЙ ТАМИРЧИН:

Д.СУМЬЯА /жүдо/ “Рио-2016” олимпын наадмын мөнгөн медальт, Азийн аварга, “Мастерс” тэмцээний аварга, Дэлхийн чансааг тэргүүлэгч.

## ОНЫ ШИЛДГИЙН ШИЛДЭГ ДАСГАЛЖУУЛАГЧ:

Х.ЭРДЭНЭТ-ОД /жүдо/  
ОНЫ ШИЛДЭГ ЭРЭГТЭЙ ТАМИРЧИН:  
Э.СОДНОМПИЛЖЭЭ /пара пауэрлифтинг/ Рио-2016” паралимпын наадмын хүрэл медальт.

Б.УУГАНХҮҮ /пара жүдо/ Рио-2016 паралимпын наадмын хүрэл медальт

## ОНЫ ШИЛДЭГ ЭМЭГТЭЙ ТАМИРЧИН:

Д.ОТГОНЦЭЦЭГ /чөлөөт бөх/ ДАШТ-ий хүрэл медальт, Ази тивийн аварга

М.АНХЦЭЦЭГ /хүндийг өргөлт/ “Рио-2016” олимпын наадмын 8-р байрын шагналт, Ази тивийн аварга, Залуучуудын дэлхийн аварга

## ОНЫ ШИЛДЭГ ДАСГАЛЖУУЛАГЧ:

Ч.БАЗАРСҮРЭН /пара жүдо/  
Д.БАТСҮРЭН /бокс/  
ОНЫ ШИЛДЭГ БАГ:

ЗхЗ Сагсан бөмбөгийн оюутны шигшээ баг / Оюутны ДАШТ-ий мөнгөн медальт/

## ОНЫ ШИЛДЭГ ЗАЛУУ ТАМИРЧИН:

Б.ТЭГШБАЯР /налуу замын дугуй/ Өсвөр үеийн дэлхийн аварга

## ОНЫ ШИЛДГИЙН ШИЛДЭГ ХОЛБОО:

Монголын жүдо бөхийн холбоо

## ОНЫ ШИЛДЭГ ХОЛБОО:

Монголын шатрын холбоо

Монголын боксын холбоо

## ОНЫ ШИЛДЭГ ЕРӨНХИЙЛӨГЧ:

Х.Баттулга /Монголын жүдо бөхийн холбоо/

## ОНЫ ШИЛДЭГ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:

Г.Ерөөлбат /Монголын гимнастикийн холбоо/

Улаанбаатарт:

Маргааш  
Өдөр -17  
Шөнө -23

Нөгөөдөр  
Өдөр -14  
Шөнө -25

Өдрийн зурхай

ӨВЛИЙН ДУНД ЦАГААН ХУЛГАНА САР ДОЛООН УЛААН МЭНГЭТЭЙ ХАР МОРЬ ӨДӨР

Наран ургах шингэх: 08.41-17.05

Үс засуулбал: Хэрүүл тэмцэл ирнэ



Тухайн өдөр нохой, хонь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Эл өдөр баяр баясгалангийн хурит үйлдэх, шинэ гэр барих, хувцас өмсөх, чимэг зүүх, бүжиг наадат үүсгэх, бурханы ёс ба тари бүтээх, атраг нохойг хураахуйд сайн. Баруун чих хангинавал асрагдах, зүүн нь бол буян арвижих, нохой уливал гэрийн тэнгэр зайлсан, хэрээ гуагааваал эд агуурс олдох, тагнай загатнавал зочин ирэх, бие татвал гаслан болох, хөл татвал хувцас олдох болой. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, торь, бич, тахиа болой.

Бидэнд тохиолдсон

ХҮНДХЭН ХӨГТЭЙ ЯВДЛУУД

Sco Mco



Автобусанд амжаад суучих санаатай гүйж байтал нэг охин машин дотроос “нэг, хоёр, нэг хоёр” гээд тушаагаад байдаг юм даа. Гэнэт аймаар хүний тушаалаар гүйгээд байгаа юм шиг санагдаад уурлаж ч болохгүй, инээж ч болохгүй, үргэлжлүүлээд гүйх нь хүртэл нэг эвгүй байх чинь хэцүү л болдог юм байна.

# SODON

cleaning service

## БҮХ ТӨРЛИЙН ЦОГИ ЦЭВЭРЛЭГЭЭ

### АЛБАН БАЙГУУЛЛАГЫН ЦЭВЭРЛЭГЭЭ

- Их цэвэрлэгээ
- Гэрээт цэвэрлэгээ
- Гадна фасадны цэвэрлэгээ
- Гадна талбайн цэвэрлэгээ
- Барилгын болон засварын дараах цэвэрлэгээ
- Үдэшилг хүлээн авалтын дараах цэвэрлэгээ

### АЙЛ ӨРЖИЙН ЦЭВЭРЛЭГЭЭ

- Их цэвэрлэгээ
- Энгийн цэвэрлэгээ
- Хэсэгчилсэн цэвэрлэгээ
- Цонх тагтны цэвэрлэгээ
- Цонх тагтны засвар үйлчилгээ
- Хивс, хивсэнээр цэвэрлэгээ

УТАС: 95018180, 88120500, 99003618

FACEBOOK: SODON SERVICE